



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

(ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ)

*БНМАУ-ын Бага Хурлын Тамгын Гавар*

№ 1

1992 оны нэг, хоёрдугаар сар

(7)

## ГАРЧИГ

### I. БНМАУ-ЫН ЕРӨНХИГЛӨГЧИЙН БАТААМЖ, БНМАУ-ЫН ХУУЛЬ

- |  |    |
|--|----|
| 1. Монгол Улсын Үндсэн хууль   | 1  |
| 2. Монгол Улсын Үндсэн хуулийн хавсраат хууль                                  | 26 |
| 3. Монгол Улсын Үндсэн хуулийн өдрийн тухай БНМАУ-ын хууль                     | 31 |
| 4. Хууль батламжаах тухай № 1  | 32 |
| 5. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын 1992 оны улсын төсвийн тухай БНМАУ-ын хууль | 33 |

### II. БНМАУ-ЫН АРДЫН ИХ ХУРАЛЫН ТОГТООЛ

- |  |    |
|--|----|
| 6. БНМАУ-ын Ардын Их Хурлын депутатын бүрэн эрхийг дуусгавар болсонд тооцох тухай № 01 | 35 |
| 7. БНМАУ-ын Ардын Их Хурлын депутатын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай № 03         | 36 |
| 8. БНМАУ-ын Ардын Их Хурлын даргыг сонгох тухай № 05                                   | 37 |
| 9. БНМАУ-ын Ардын Их Хурлын орлогч дарга нарыг сонгох тухай № 06                       | 37 |
| 10. БНМАУ-ын Ардын Их Хурлын даргыг чөлөөлөх тухай № 07                                | 38 |
| 11. БНМАУ-ын Ардын Их Хурлын орлогч дарга нарыг чөлөөлөх тухай № 08                    | 39 |
| 12. Монгол Улсын Үндсэн хууль нийтлэх тухай № 14                                       | 39 |
| 13. Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай № 17  | 40 |
| 14. Зарим хүнийг БНМАУ-ын Бага Хурлын гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх тухай № 21       | 41 |

- |   |    |
|---|----|
| 15. БНМАУ-ын Бага Хурлын зарим гишүүнийг<br>нохон сонгох тухай № 24 | 42 |
| 16. БНМАУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны тухай № 25              | 43 |
| 17. БНМАУ-ын Бага Хурлын үйл ажиллагааны тухай № 26                 | 45 |

### III. БНМАУ-ЫН БАГА ХУРАЛЫН ТОГТООЛ

- |  |    |
|--|----|
| 18. Монгол банкны 1992 оны өрлөг, зарлагын төсвийг<br>батлах тухай № 07          | 47 |
| 19. Улсын 1990 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан батлах тухай № 08                 | 48 |
| 20. БНМАУ-ын өдийн засаг, нийгмийг 1992 онд хөгжүүлэх<br>чиглэлийн тухай № 10    | 49 |
| 21. Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалагчид авахыг<br>зөвшөөрөх тухай № 11 | 50 |
| 22. Төлөвлөгөө батлах тухай № 14   | 51 |

### IV. БНМАУ-ЫН ЕРӨНХИГЛЭГЧИЙН ЗАРАЛГ

- |  |    |
|--|----|
| 23. Засаг хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллаагчийн офицер,<br>эхлэгчдийн тангарыг батлах тухай № 01   | 58 |
| 24. Лувсандоржийн Давраагийн элчин сайдаар томлох тухай № 02   | 59 |
| 25. Гэндэнгийн Нямдоог элчин сайдын үүрэгт ахлаас<br>члолох тухай № 03                               | 59 |
| 26. Инжигийн Отгорбаяг элчин сайдын үүрэгт ахлаас<br>члолох тухай № 05                               | 60 |
| 27. Монгол Улсын Үндсэн хуулийг уас дээр мөрдөж эхлэснийг<br>зарим тусхаглах ёсоор үйлдэх тухай № 07 | 60 |
| 28. Монголын ард түмний ахмад үеийн талар баримтлах<br>төрийн бодлогын тухай № 15                    | 61 |

Монголын ард түмэн бид.

— улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,

— хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,

— төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг найдиглан өсгөж,

— хүн төрөлхтөний соёл иргэншлийн олоолтыг хүндэтгэн үзэж,

— өх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүдэхийг эрхэм зорилго болгоно. Үүний учир Монгол Улсын Үндсэн хуулийг давар олноо зарлан тунхаглаж байна.

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### МОНГОЛ УЛСЫН БҮРЭН ЭРХТ БАЙДАЛ

#### *Нэгдүгээр зүйл*

1. Монгол Улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд найрамдах улс мөн.

2. Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.

#### *Хоёрдугаар зүйл*

1. Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна.

2. Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдана.

#### *Гуравдугаар зүйл*

1. Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллаагаараа уламжлан гэнэхүү эрхээ эдэлнэ.

2. Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, авахаар завдахыг хориглоно.

### *Дөрөвдүгээр зүйл*

1. Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хиа халдаггүйн дархан байна.

2. Монгол Улсын хилнийг хуулиар бататгана.

3. Хууль гаргахгүйгээр гадаадын цэргийн хүчнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлуулах, дамжин өнгөрүүлэхээр улсын хиа нэвтрүүлэхийг хориглоно.

### *Тавдугаар зүйл*

1. Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, сөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн одоо хэвшил бүхий эдийн засагтай байна.

2. Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.

3. Өмчлөгчийн эрхийг гэгцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.

4. Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдла, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.

5. Мил сүрэг бол үндэсний бахааг мөн бөгөөд төрийн хамгаалаатад байна.

### *Зургадугаар зүйл*

1. Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гэгцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалаатад байна.

2. Монгол Улсын иргэдэд өмчлүүлдснээс бусад газар, түүнд хэрхэн хэвлий, түүний байлаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн.

3. Бусдаар, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнхээс бусад газрыг хөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно. Энэ нь газрын хэвлийг өмчлөхөд хамаарахгүй. Иргэд хувийн өмчийнхөө газрыг худалдах, ариажих, бэлэглэх, барьцаалах зэргээр гадаадын иргэн, харьяалаагүй хүний өмчлөлд шилжүүлэх, түүндэн төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусдад эзэмшүүлэх, ашиглуулахыг хориглоно.

4. Төр газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, улсын тусгай хэрэгцээг үндэслэн мөхөх олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уг газрыг хүн амын эрүүл мэнд,

байгааг хамгаалаа, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлалт ашиглахаа хуряан ахи болно.

5. Төрөөс гадаадын иргэн, хуулийн этгээд, харьцалалгүй хүнд газрыг төлбөр, хугацаатайгээр болон хуульд заасан бусад болзол, журмаар ашиглуулж болно.

### *Долдугаар зүйл*

1. Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалаалтад байна.

2. Иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийнх эрх мэт, Монгол Улсын үндэсний баялаг мөн.

### *Наймдугаар зүйл*

1. Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх эх хэлвэрээ суралцах, хариуцах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг үл хондонго.

### *Есдүгээр зүйл*

1. Монгол Улсад төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дэвдэнэ.

2. Төрийн байгууллага шашны, сүм хийд улс төрийн үйл ажиллагаа эрхлэн явуулж болохгүй.

3. Төр, сүм хийдийн хоорондын харилцааг хуулиар зохицуулна.

### *Аравдугаар зүйл*

1. Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмэлсэн гадаад бодлого явуулна.

2. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.

3. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан бузуу нэгдэн өрсөн тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтсэмжийн нэгэн адна үйлчилнэ.

4. Монгол Улс Үндсэн хуульдаа харшигласан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй.

### *Арван нэгдүгээр зүйл*

1. Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.

2. Монгол Улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна. Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, түүнд алба хаах журмыг хуулиар тогтооно.

*Арван хоёрдугаар зүйл*

1. Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалыг бэлгэ тэмдэг нь Төрийн сүлд, туг, далбаа, тамга, дуулаа мөн.

2. Төрийн сүлд, туг, далбаа, дуулаа нь Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүдэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлнэ.

3. Төрийн сүлд нь ариун цагаан өнгийн бадам цэцэг суурьтай, төгсгөлгүй үргэлжлэн дэлгэрэх түмэн насан хэргээр хөвөөлсөн, мөнх тэнгэрийг бэлгэдсэн дугариг хөх дэвсгэртэй байна. Сүлдийн төв хэсэгт Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, цог хийморийг илтгэсэн алтан соёмбо, эрдэнийн хүлгийг хослуулан дүрсэлсэн байна. Сүлдийн хүрээний магнайн хэсэгт эрт, эдүгээ, ирээдүй гурван цагийг бэлгэдсэн хүслийг хангагч чандмань эрдэнэ, доод хэсэгт эх газрыг төлөөлсөн ногоон өнгийн уулан хээ, ашид дэвжихийн өлзий хутаг оршсон хүрдийг тус тус дүрсэлнэ. Хүрдийг хадгаар дээдлэн сүлжсэн байна.

4. Монголын нэгдсэн тулгар төрийн уламжлалт Их цагаан туг нь Монгол Улсын төрийн хүндэтгэлийн бэлгэдэл мөн.

5. Монгол Улсын төрийн далбаа нь улаан, хөх, улаан хосолсон өнгөтэй байна. Далбааны гурав хуваасны нэгийн хэмжээтэй дундах хэсэг нь мөнх тэнгэрийн хөх, түүний хоёр тал нь мандан бөдрөхийн бэлгэдэл улаан өнгөтэй байна. Далбааны ншин талын улаан дэвсгэрийн төв хэсэгт алтан соёмбо байрлуулна. Далбааны өргөн, урт нь 1:2-ын харьцаатай байна.

6. Төрийн тамга дөрвөлжин хэлбэртэй, голдоо төрийн сүлдтэй, сүлдийн хоёр талаар Монгол Улс гэсэн бичвэстэй, арслангийн дүрс бүхий баруутай байна. Төрийн тамгыг Монгол Улсын Ерөнхийлөгч барина.

7. Төрийн бэлгэ тэмдгийг дээдлэн хэрэглэх журам, төрийн дуулалыг үг, алыг хуулиар бататгана.

*Арван тэрвдүгээр зүйл*

1. Монгол Улсын төрийн дээд байгууллагууд байнга оршдог хотыг Улсын нийслэл гэнэ. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот мөн.

2. Монгол Улсын нийслэлийн эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ

#### *Арсан дөрөндүгээр зүйл*

1. Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.

2. Хүнийг үндэс, угсаа, дээд, арьсны өнгө, нас, хүйс, нийгэмийн гараал, бийдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, алба, туслаал, шашин шүтээг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхайл үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.

#### *Арсан тавдугаар зүйл*

1. Монгол Улсын иргэний харьяалаал хийгээд харьяат болох харьяатаас гарах үндэслэл, журмыг гагцхүү хуулиар тогтооно.

2. Монгол Улсын иргэнийг харьяатаас хасгах, эх орноосоо мөөх, өөр улсад иянажүүлэн өгөхийг хориглоно.

#### *Арсан зургадугаар зүйл*

Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

1) амьд явах эрхтэй. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэргийг үндэсний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор яамн дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусивулахыг хатуу хориглоно;

2) эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцвэ аадгизлаас хамгаалуулах эрхтэй;

3) хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өл залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан эвэлж хориглоно. Төр, түүний эрх бүхий байгуулалта нь нийгмийн зайлашгүй хэргээр үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан албал нөтөх олговор, үнийг төлнө;

4) ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн алтад нөхцөлөөр хайгуудых, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрдүүлж болохгүй;

5) өндөр наслах, хөдөлмөрийн чадвар аадах, түүхэд төрүүлэх, асрах болон хуульд эзэсэн бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй;

6) эрүүл мэндөө хамгаалуулах, эмчлэгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмчлэгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно.

7) сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажлаалуулж болно;

8) соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй, Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална;

9) шууд буюу төлөөлөгчдийн байгууллаагаараа уламжлан төрийг удирдах хэргт оролцох эрхтэй. Төрийн байгууллаагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно;

10) нийгмийн бодол өвөгдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулаж, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахих, хуулийг дэвдэн биелүүлэн, Аал иргэн нам, олон нийтийн бусад байгууллаагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүнийг нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намны гишүүнийг түдгэлзүүлж болно;

11) улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх няхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална;

12) төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй;

13) халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур нэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгала, хүнлэг бус, хэргийг халдаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шаатгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүнийг гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мөдөгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална;

14) Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх,



үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслаацаа авах, нотлох баримтыг шаалгуулах, шударга шүүхээр шүүгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролдох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахаат үзүүлэх хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутныг ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно;

15) шашин шүтэх, өс шүтэх эрх чөлөөтэй;

16) итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно;

17) төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбад зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зоригоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;

18) удсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно.

#### *Арван долдугаар зүйл*

1. Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн дараахь үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ:

1) Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх;

2) хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

3) хуулиар ногдуулсан албан татвар төлөх;

4) эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах.

2. Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн.

#### *Арван наймдугаар зүйл*

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэний эрх, үүргийг Монгол Улсын хууль, уул иргэнийг харьяалсан улстай байгуулсан гэрээгээр тогтооно.

2. Монгол Улс олон улсын гэрээгээр гадаадын иргэний эрх, үүргийг тодорхойлохдоо уул иргэнийг харьяалсан улстай энэ талаар харилцан адил байх зарчим баримтална.

3. Монгол Улс нутаг дэвсгэртээ байгаа харьяалаагүй хүний эрх, үүргийг өөрийн хуулиар тогтооно.

4. Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа уамлас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалаагүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргавал Монгол Улсад орогнох эрх олгож болно.

5. Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлд заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалаагүй хүнд эдлүүлэхдээ Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлал тогтоож болно.

#### *Арван есдүгээр зүйл*

1. Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц өдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.

2. Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, өс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч өрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэргийн хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө.

3. Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БАЙГУУЛАА

#### НЭГ. Монгол Улсын Их Хурал

##### *Хорьдугаар зүйл*

Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.

### *Хорин нэгдүгээр зүйл*

1. Улсын Их Хурал нэг танхимтай, далан зургаан гишүүнтэй байна.

2. Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.

3. Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно.

4. Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно.

### *Хорин хоёрдугаар зүйл*

1. Улсын нийт нутаг дэвсгэр буюу зарим хэсгийг нь хамарсан гэнэтийн аюул тохиолдсон, дайны ба нийтийн эмх замбараагүй байдал үүссэн зэрэг онцгой нөхцөлийн улмаас ээлжит сонгууль явуулах боломжгүй бол мөнхүү нөхцөл арилж, шинэ сонгогдсон гишүүдээ тангараг өргөтөл Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлнэ.

2. Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзсэнээр буюу эсхүл мөнхүү шалтгаанаар Ерөнхийлөгч Улсын Их Хурлын даргатай зөвшилцөн санал болгосноор өөрөө тарах шийдвэр гаргаж болно. Ийнхүү тарах шийдвэр гаргасан бол шинэ сонгогдсон гишүүдээ тангараг өргөтөл Улсын Их Хурал бүрэн эрхээ эдэлнэ.

### *Хорин гурвдугаар зүйл*

1. Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.

2. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх нь Төрийн сүлдэндээ тангараг өргөснөөр ихэлж, Улсын Их Хурлын даргагийн сонгуулиар шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөснөөр дуусгавар болно.

### *Хорин дөрөвдүгээр зүйл*

1. Улсын Их Хурлын дарга, дэд даргыг Улсын Их Хурлын гишүүдийн дотроос нэр дэвшүүлэн саналаа нууцаар гаргаж сонгоно.

2. Улсын Их Хурлын дарга, дэд даргын бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байх бөгөөд хуульд заасан үндэслэлээр хугацаанаас нь өмнө чөлөөлж, огцруулж болно.

### Хорин төвдүгээр зүйл

1. Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудалыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дарааль асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ:

1) хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;

2) төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох;

3) Ерөнхийлөгчийн ба Улсын Их Хурал, түүний гишүүний сонгуулийг товлон зарлах;

4) Улсын Их Хурлын Байнгын хороо, Засгийн газар, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнийг тогтоох, өөрчлөх;

5) Ерөнхийлөгчийг сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргах, чөлөөлөх, огцруулах;

6) Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах;

7) төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах;

8) хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах;

9) улсын хиа тогтоох;

10) Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, бүрэн эрхийг тогтоох;

11) Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг батлах, өөрчлөх;

12) нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын тогтоолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох;

13) улсын цол, одон, медаль, цэргийн дээд цол бий болгох, төрийн албаны зарим тусгай салбарын албан тушаалын зэрэг дэвгийг тогтоох;

14) өршөөл үзүүлэх шийдвэр гаргах;

15) Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах, гадаад улстай дипломат харилцаа тогтоох, цуцлах;

16) ард нийтийн санаа асуулга явуулах, Сонгуулийн эрх бүхий иргэдийн олонхи нь оролцсон ард нийтийн санаа асуул-

гьт хүчинтэйд тооцож, олонхийн санаал авсан асуудлыг шийд-  
вэрлэгдсэн гэж үзнэ;

17) Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд бу-  
сад улсаас аюул санаал учруулж, зэвсэглэл халдвал дайн бүхий  
байдал зарлах, цуцлах;

18) энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөлд  
улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон  
дайны байдал зарлах, эсхүл энэ тухай гаргасан Ерөнхийлөг-  
чийн зарлигийг батлах, хүчингүй болгох.

2. Дараахь онцгой нөхцөл бий болсон үед үр дагаврыг нь  
арнагах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгохын тулд  
онц байдал зарлаж болно:

1) улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь оршин  
суугаа хүн, амын амь нас, эрүүд мэнд, аж амьдрал, нийтийн  
аюулгүй байдалд шууд аюул учруулсам буюу учруулахуйц бай-  
галийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон;

2) Үндсэн хуулийн дэг журам, нийгмийн хууль ёсны тог-  
тооцоо оршин тогтноход санаахийлсэн аливаа байгууллага, бү-  
лэг хүний зохион байгуулалт бүхий хүч хэрэглэсэн хууль бус  
үйл ажиллагааны улмаас үүссэн нийтийн эмх замбараагүй байд-  
лыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор ердийн арга  
хэрэгсэлээр тохиуулах боломжгүй болсон.

3. Улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь ний-  
тийн эмх замбараагүй байдал үүсч, зэвсэгт мөргөлдөөнд хүр-  
сэн, тийм мөргөлдөөн гэрэх бодит аюул бий болсон, бусад ул-  
саас цэргийн хүчээр түрэмгийлэн халдсан, эсхүл тийнхүү хал-  
дах нь бодитой болсон үед дайны байдал зарлаж болно.

4. Улсын Их Хурал бусад бүрэн эрх, зохион байгуулалт,  
үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.

#### *Хорин жургалуугаар зүйл*

1. Ерөнхийлөгч, Улсын Их Хуралын гишүүн, Засгийн газар  
хууль санаачлах эрх эдэлнэ.

2. Иргэд, бусад байгууллага хуулийн төсвийн тухай сана-  
лаа хууль санаачлагчид уламжлана.

3. Монгол Улсын хуулийг Улсын Их Хурал албан ёсоор  
нийтлэх бөгөөд хэрэв хуульд өөрөөр заагаагүй бол нийлхүү ний-  
тэлснээс хойш арав хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

#### *Хорин долдугаар зүйл*

1. Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, зохион байгуу-  
лалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ.

2. Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа далан таваас доошгүй ажлын өдөр чуулна.

3. Улсын Их Хурлын гишүүдийн гуравны нэгээс дээшхийн шаардсанаар, эсхүл Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын даргын санаачлагаар ээлжит бус чуулган чуулж болно.

4. Улсын Их Хурлын анхдугаар чуулганыг сонгууль явуулсан өдрөөс хойш гуч хоногийн дотор Ерөнхийлөгч, бусад чуулганыг Улсын Их Хурлын дарга товлон зарлана.

5. Ерөнхийлөгч онц болон дайны байдал зарлавал түүнээс хойш далан хоёр цагийн дотор Улсын Их Хурал онцгой чуулганаа тусгайлан товлдохгүйгээр чуулна.

6. Үндсэн хууль, бусад хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын нийт гишүүний дийлэнх олонхи нь хүрэлцэн ирнээр чуулганыг хүчинтэйд үзэж, чуулганд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

#### *Хорин наймдугаар зүйл*

1. Улсын Их Хурал үйл ажиллагааныхаа зохих салбар, чиглэлээр Байнгын хороодтой байна.

2. Байнгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Улсын Их Хурал тогтооно.

#### *Хорин есдүгээр зүйл*

1. Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. Улсын Их Хурлын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хансарч болохгүй.

2. Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална.

3. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.

#### *ХОЕР. Монгол Улсын Ерөнхийлөгч*

#### *Гучдугаар зүйл*

1. Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн.

2. Ерөнхийлөгчөөр дөчин таван нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.

*Гучин нэгдүгээр зүйл*

1. Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай байна.

2. Улсын Их Хуралд суудаал бүхий нам дангаараа буюу хамтран Ерөнхийлөгчид тус бүр нэг хүний нэр дэвшүүлнэ.

3. Анхан шатны сонгуульд Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхтэй оролцож, Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн талаар саналаа нууцаар гаргана.

4. Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргана.

5. Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч нийхүү сонгогчдын олонхийн санал аваагүй бол анхны санал хураалтад оролцсон нийт сонгогчийн хамгийн олон санал авсан хоёр хүнийг дахин санал хураалтад оруулна. Дахин санал хураалтаар сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргана.

6. Хэрэв хоёр дахь санал хураалтаар Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч нийхүү сонгогчдын олонхийн санал аваагүй бол дахин сонгууль явуулна.

7. Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируудан сонгож болно.

8. Ерөнхийлөгч нь Ерөнхий сайд, Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй. Хэрэв Ерөнхийлөгч өөр ажил, албан тушаал эрхэлж байгаа бол тангараг өргөсөн өдрөөсөө эхлэн уул үүргээс чөлөөлөгдөнө.

*Гучин хоёрдугаар зүйл*

1. Ерөнхийлөгчийн бүрэн эрх тангараг өргөснөөр эхлэн, шинэ сонгогдсон Ерөнхийлөгч тангараг өргөснөөр дуусгавар болно.

2. Ерөнхийлөгч сонгогдсоноосоо хойш гуч хоногийн дотор «Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, ард түмнийхээ эрх чөлөө, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн хамгаалж, Үндсэн хуулийг дээдлэн сахиж, Ерөнхийлөгчийн үүргийг шударгаар биелүүлэхэв батлан тангараглая» хэмээн Улсын Их Хуралд тангараг өргөнө.

*Гучин гуравдугаар зүйл*

1. Ерөнхийлөгч дараахь үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих. Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж, чуулганд оролцсон нийт гишүүний гуравны хоёр нь хүлээж аваагүй бол уг хууль, шийдвэр хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ;

2) Улсын Их Хуралд олонхи суудал авсан намтай, аль ч нам олонхийн суудал аваагүй бол Улсын Их Хуралд суудал авсан намуудтай зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох санал, түүнчлэн Засгийн газрыг огцруулах саналыг Улсын Их Хуралд оруулах;

3) өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх. Энэ талаар Ерөнхийлөгч зарлиг гаргавал түүнд Ерөнхий сайд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно;

4) гадаад харилцаанд улсаа бүрэн эрхтэй төлөөлж, Улсын Их Хуралтай зөвшилцөн Монгол Улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулах;

5) Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг Улсын Их Хуралтай зөвшилцөн томилох буюу эгүүлэн татах;

6) Монгол Улсад суух гадаад улсын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авах;

7) улсын цол, цэргийн дээд цол хүртээх, одон, медалиар шагнах;

8) уучлал үзүүлэх;

9) Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах, тус улсад орогнох эрх олгох асуудлыг шийдвэрлэх;

10) Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг зөвлөлийг тэргүүлэх;

11) бүх нийтийн буюу хэсэгчилсэн цэргийн дайчлалыг зарлах;

12) Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болбол Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт, хойшлуулашгүй тохиолдолд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, түүнчлэн цэрэг хөдөлгөх захирамж өгөх. Онц байдал, дайны байдал зарласан Ерөнхийлөгчийн зарлигийг Улсын Их Хурал уул зарлиг гарснаас хойш долоо хоногийн дотор хэлэлцэж батлах буюу хүчингүй болгоно. Хэрэв Улсын Их Хурал шийдвэр гаргаагүй бол уул зарлиг хүчингүй болно.

2. Ерөнхийлөгч Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна.



3. Ерөнхийлөгч Улсын Их Хуралд болон ард түмэндээ хандан нэгээлт гаргаж, чуулганд өөрийн тээллээр оролцон улс орны дотоод, гаднаад байдлын нэн чухал асуудлаар мэдээлж, саналаа оруулж болно.

4. Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн хуулиар олгож болно.

#### *Гучин дөрөвдүгээр зүйл*

1. Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд хуульд нийцүүлэн зарлиг гаргана.

2. Ерөнхийлөгчийн зарлиг хуульд нийцээгүй бол Ерөнхийлөгч өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно.

#### *Гучин тавдугаар зүйл*

1. Ерөнхийлөгч Улсын Их Хуралд ажлаа харуцна.

2. Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчөөд Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаар хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний дийлэнх олонхийн саналаар огцруулна.

#### *Гучин зургадугаар зүйл*

1. Ерөнхийлөгчийн бие, өргөө, унаа халдашгүй дархан байна.

2. Ерөнхийлөгчийн нэр төр, халдашгүй байдлыг хуулиар хамгаална.

#### *Гучин долдугаар зүйл*

1. Ерөнхийлөгчийг түр эзгүйд бүрэн эрхийг нь Улсын Их Хурлын дарга хэрэгжүүлнэ.

2. Ерөнхийлөгч огцорсон, нас нөгчсөн, хүсэлтээрээ чөлөөлөгдсөн бол Ерөнхийлөгч шинээр сонгогдож тангараг өргөх хүртэл бүрэн эрхийг нь Улсын Их Хурлын дарга хэрэгжүүлнэ. Энэ тохиолдолд Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн сонгуулийг дөрвөн сарын дотор зарлан явуулна.

3. Улсын Их Хурлын дарга Ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэх журмыг хуулиар тогтооно.

### **ГУРАВ. Монгол Улсын Засгийн тавар**

#### *Гучин наймдугаар зүйл*

1. Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн.

2. Засгийн газар төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулаалтыг удирдах нийтлэг чиг үүргийн дагуу дараахь үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлэнэ:

1) Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулаж хангах;

2) шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, эрэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх;

3) салбарын ба салбар хоорондын, түүнчлэн бүс нутгийн хөгжлийн асуудлаар арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх;

4) хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялагийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авах;

5) төрийн захиргааны төв байгууллагыг шуурхай удирдаж, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх;

6) улсыг батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлж, үндэсний аюулгүй байдлыг хангах;

7) хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй зэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

8) төрийн гадаад бодлого хэрэгжүүлэх;

9) Улсын Их Хуралтай зөвшилцөж дараа соёрхон батлуудахаар Монгол Улсын олон улсын гэрээ байгуулах, хэрэгжүүлэх, түүнчлэн Засгийн газар хоорондын гэрээ байгуулах, цуцлах.

3. Засгийн газрын төдөрхөй бүрэн эрх, зохион байгуулаалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.

#### *Гушин гэдүгээр зүйл*

1. Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ.

2. Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрвэдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах сандалаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

3. Засгийн газрын гишүүдийг Ерөнхий сайдын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хүн бүрээр хэлэлцэж томилно.

#### *Дөмдүгээр зүйл*

1. Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна.

2. Засгийн газрын бүрэн эрх Улсын Их Хурлаас Ерөнхий сайдыг томиасноор эхэлж, шинэ Ерөнхий сайдыг томиасноор дуусгавар болно.

*Дөчин нэгдүгээр зүйл*

1. Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биедүүлэх ажалыг Улсын Их Хурлын өмнө хариуцна.

2. Засгийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана.

*Дөчин хоёрдугаар зүйл*

Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална.

*Дөчин гуравдугаар зүйл*

1. Засгийн газар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл хугацаа дуусахаас өмнө огцрох тухайгаа Ерөнхий сайд Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно.

2. Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүдийн тэн халас нь нэгэн зэрэг огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно.

3. Улсын Их Хурал Засгийн газрыг огцруулах тухай өөрөө санаачласан болон Ерөнхийлөгчийн санаа, Ерөнхий сайдын мэдэгдэлийг хүлээн авснаас хойш арван тав хоногийн дотор Засгийн газрыг огцруулах эсэхийг хэлэлцэн шийдвэрлэнэ.

4. Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Засгийн газрыг огцруулах тухай санааыг албан ёсоор тавибал Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэнэ.

*Дөчин дөрөвдүгээр зүйл*

Өөрт нь итгэл хүлээлгэж байгаа эсэхийг илэрхийлж өгөхийг хүсч Засгийн газар тогтоолын төсөл оруулбал Улсын Их Хурал уул асуудлыг дөчин гуравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан журмаар шийдвэрлэнэ.

*Дөчин тавдугаар зүйл*

1. Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах бөгөөд түүнд Ерөнхий сайд, тухайн шийдвэрийн биелэлтийг хариуцсан сайд газрын үсэг зурна.

2. Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно.

*Дөчин зургадугаар зүйл*

1. Монгол Улсын яам, төрийн бусад албан газрыг хуулийн дагуу байгуулна.

2. Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч Монгол Улсын иргэн байх бөгөөд Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж ард түмнийхөө тусын тулд, иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллана.

3. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно.

### *ДӨРӨВ. Шүүх эрх мэдэл*

#### *Дочин долдугаар зүйл*

1. Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.

2. Ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно.

3. Шүүхийг зөвхөн Үндсэн хууль, бусад хуулийн дагуу байгуулна.

#### *Дочин наймдугаар зүйл*

1. Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажил төрлөөр шүүхийг дагнаж байгуулаж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байх үл болно.

2. Шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.

3. Шүүх улсын төсвөөс санхүүжинэ. Шүүх үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана.

#### *Дочин есдүгээр зүйл*

1. Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.

2. Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хандлагатаас оролцох болохгүй.

3. Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана.

4. Шүүхийн ерөнхий зөвлөл шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр, гагцхүү хуульчдаас шүүгчийг сонгож сонгох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийг бие даан ажиллах мэдцлөөр хангахтай холбогдсон үүргийг биелүүлнэ.

5. Шүүхийн ерөнхий зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.

### *Тавьдугаар зүйл*

1. Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллаага мөн бөгөөд дарлаахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) хуулиар харьяалуулсан эрүүгийн хэрэг, эрх зүйн маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх;

2) давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх;

3) хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талар Үндсэн хуулийн цац, Улсын ерөнхий прокуророос шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх;

4) Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талар албан ёсны тайлбар гаргах;

5) хуулиар эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх.

2. Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ.

3. Улсын дээд шүүх, бусад шүүх нь Үндсэн хуульд нийцвэргүй, албан ёсоор нийтлэвгүй хуулийг хэрэглэх эрхгүй.

### *Тавин нэгдүгээр зүйл*

1. Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ.

2. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хурал тайлацуулснаар, бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санхал болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно. Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санхал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно.

3. Хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арван доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр; хууль зүйн дээд боловсролтой, гурван доошгүй жил мэргэжлээрээ ажилласан Монгол Улсын хөрөн таван нас хүрсэн иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно.

4. Үндсэн хууль, шүүхийн тухай хуульд тавсан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно.

### *Тавин хоёрдугаар зүйл*

1. Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ.

2. Анхан шатны шүүх хэрэг, маргааныг замтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна.

3. Хуульд тусгайлан зүйлчилж заасан зарим хэргийг шүүгч дангаар хянан шийдвэрлэж болно.

*Тавин тусгайгаар зүйл*

1. Шүүн таслах ажиллагааг монгол хэлээр явуулна.

2. Монгол хэл мэдэхгүй хүнд хэргийн баоимт салтийг хэлмэрчлүүлэн бүрэн танилцуулах бөгөөд шүүх хуралдаан дээр өх хэлээр нь үг хэлэх эрх олгоно.

*Тавин дөрөвдүгээр зүйл*

Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүх хэргийг на таслан шийдвэрлэнэ.

*Тавин тусгайгаар зүйл*

1. Шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрхтэй.

2. Шүүгдэгчид энэ эрхээ адалхад хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслаацаа үзүүлнэ.

*Тавин зургадугаар зүйл*

1. Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно.

2. Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно.

3. Монгол Улсын прокурорын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДААГА

*Тавин долдугаар зүйл*

1. Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэл, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд зуваагдана.

2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.

3. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан тухайн нутгийн Хураал, иргэдийн саналыг үндэслэн Улсын Их Хураал шийдвэрлэнэ.

*Тавин наймдугаар зүйл*

1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн.

2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хураал батална.

*Тавин есдүгээр зүйл*

1. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёслг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ.

2. Нутгийн өөрөө удирдах байгууллага бол аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийд иргэдийн Төлөөлөгчдийн Хураал, баг, хороод иргэдийн Нийтийн Хураал, тухайн Хурлын хуралдааны чөлөө цагт түүний Тэргүүлэгчид мөн.

3. Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн Хурлыг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно. Эдгээр Хурлын болон сум, дүүргийн Хурлын төлөөлөгчдийн тоо, сонгох журмыг хуулиар тогтооно.

*Жордугаар зүйл*

1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хэрэгжүүлнэ.

2. Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд; сум, дүүргийн Засаг даргыг харьяалах аймаг, нийслэлийн Засаг дарга; баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус дөрвөн жилийн хугацаагаар томилно.

3. Ерөнхий сайд буюу дээд шатны нэгжийн Засаг дарга доод шатныхаа нэгжийн Засаг даргад нэр дэвшэгчийг томилгохоос татгалзсал энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмаар дахин нэр дэвшүүлж томилол өмнөх Засаг дарга бүрэн эрхээ хэвээр хадгална.

*Жаран нэгдүгээр зүйл*

1. Засаг дарга тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт засаг төрийн төлөөлөгчийн зүгээс төрөл нутаг дэвсгэр-

тээ хууль тогтоомж, Засгийн газар, харьяалах дээд шатныхаа байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг Засгийн газар, дээд шатны Засаг даргын өмнө харууцна.

2. Засаг дарга тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлын шийдвэрт хориг тавих эрхтэй.

3. Тавьсан хоригийг нь Хурал өөрийн төлөөлөгчдийн олонхийн сангалаар няцаасан нөхцөлд Засаг дарга уул шийдвэрийг биелүүлэх боломжгүй гэж үзвэл огцрох хүсэлтээ зохих Хурал, Ерөнхий сайд буюу харьяалах дээд шатны Засаг даргад гаргаж болно.

4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар мөн. Тамгын газрын бүтэц, орон тооны хэлгээрыг Засгийн газар нэг бүрчлэн буюу нэг малгаар тогтооно.

### *Жаран хоёрдугаар зүйл*

1. Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна.

2. Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно.

3. Улсын Их Хурал, Засгийн газраас шаардлагатай хэмвэн үзсэн тохиолдолд өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг шийдвэрлүүлэхээр аймаг, нийслэлийн Хурал, Засаг даргад илалжүүлж болно.

### *Жаран гуравдугаар зүйл*

1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурал эрх хэмжээнийхээ дотор тогтоол, Засаг дарга захирамж гаргана.

2. Хурлын тогтоол, Засаг даргын захирамж нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлыг, Засгийн газар, харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрт нийцсэн байх бөгөөд түүнийг тус тусын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр дагаж мөрдөнө.

3. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын эрх хэмжээ, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.



## ТАВДУГААР БҮЛЭГ

### МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ

#### *Таран дөрөвдүгээр зүйл*

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүнийг заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.

2. Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдөө гэгцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.

3. Үндсэн хуулийн цэцийн гишүүнхй хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагданз.

#### *Таран тавдугаар зүйл*

1. Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгэврийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.

2. Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр хууль зүй, улс төрийн ондөр мэргэшилтэй, Монгол Улсын дотин нас хүрсэн иргэнийг томилно.

3. Үндсэн хуулийн цэцийн даргаар есөн гишүүний аль нэгийг гурван жилийн хугацаагаар гишүүдийн олонхийн саналаар сонгоно. Түүнийг нэг удаа уанруулан сонгож болно.

4. Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүн хууль зөрчвөл Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, анх илгээсэн байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал эгүүлэн татаж болно.

5. Үндсэн хуулийн цэцийн бүрэлдэхүүнд Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн шүүгч орж үл болно.

#### *Таран зургадугаар зүйл*

1. Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мөдөвлэлийн дагуу өөрийн санаачлагаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд,

Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ.

2. Үндсэн хуулийн цэц энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр дараахь маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна:

1) хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;

2) ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;

3) Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх;

4) Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг өгүүлэн татах үндэсвэл байгаа эсэх.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасны дагуу оруулсан дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол Үндсэн хуулийн цэц дахин хянан үзэж эцсийн шийдвэр гаргана.

4. Хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ нь Үндсэн хуульд нийцээгүй гэж Үндсэн хуулийн цэц шийдвэр гаргавал зохих хууль, зарлиг, батламж, шийдвэр хүчингүй болно.

*Жаран долдугаар зүйл*

Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болно.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

### МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

*Жаран наймдугаар зүйл*

1. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн цэц Улсын Их Хуралд өргөн барьж болно.

2. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Улсын Их Хурлын гишүүдийн гуравны хоёроос доошгүйн санаагаар ард нийтийн санаа асуулага явуулж болно. Санаа асуулагыг Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16-д заасан үндэслэлийн дагуу явуулна.

### *Жаран еслүгээр зүйл*

1. Үндсэн хууль, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн санаагаар батална.

2. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хуралд хоёр удаа авч хэлэлцэхэд нийхүү нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн санаа авч эс чадвал уул төслийг ээлжит сонгуулиар сонгогдсон Улсын Их Хурлын шинэ бүрэлдэхүүн ажлаа эхэлтэл дахин авч хэлэлцэхгүй.

3. Улсын Их Хурал ээлжит сонгууль явуулахын өмнөх зургаан сарын дотор Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж үл болно.

4. Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуулийн нэгэн адил хүчинтэй байна.

### *Долдугаар зүйл*

1. Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.

2. Монгол Улсын Үндсэн хуулийг 1992 оны хоёрдугаар сарын 12-ны өдрийн 12 цаг буюу арван долдугаар жарны усан бичин жилийн хаврын тэргүүн хар барс сарын шинийн есний өдрийн барилдлагаатай өлзийт сайн шар морин өдрийн морин цагаас эхлэн улс даяар дагаж мөрдөнө.

Мэдэгтүн, сахигтун!

## **БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН АРДЫН ИХ ХУРАЛ**

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН  
ХАВСРАЛТ ХУУЛЬ

БНМАУ-ЫН ҮНДСЭН ХУУЛИАС МОНГОЛ УЛСЫН  
ҮНДСЭН ХУУЛИЙГ БҮРНЭЭ ДАГАЖ  
МӨРДӨХӨД ШИНЭЖИХ ТУХАЙ

*Нэгдүгээр зүйл. Монгол Улсын хууль тогтоох ба гүйцэтгэх дээд байгууллагуудыг Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар шинэчлэн байгуулах*

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийг Монгол Улсын Үндсэн хуульд заасан зарчмын дагуу 1992 оны зургадугаар сард багтаан явуулсны үндсэн дээр Монгол Улсын Их Хурлыг, түүнээс Монгол Улсын Засгийн газрыг тус тус байгуулна.

2. Улсын Их Хурал, Засгийн газар шинэчлэн байгуулагдаж, тэдгээрийн бүрэн эрх эхлэх хүртэл хугацаанд БНМАУ-ын Ардын Их Хурал, БНМАУ-ын Бага Хурлын бүрэн эрхийн хугацаа хэвээр үргэлжилнэ. Энэ хугацаанд:

1) Ардын Их Хурал нь төрийн дотсон, гадаад бодлогын ямар ч асуудлыг сансарчлалаараа хэлэлцэн шийдвэрлэж болохоос гадна Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийг сонгох, чөлөөлөх, огцруулах, Улсын Бага Хурлын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх зэсгийн 6, 7-д зааснаар Ерөнхий сайдыг томилох, өөрчлөх, огцруулах, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлох, түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн жаран есдүгээр зүйлд заасан бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлнэ;

2) Улсын Бага Хурал энэхүү Хавсралт хуулиар Ардын Их Хурлын онцгой эрхэд хамааруулснаас бусад асуудлаар Монгол Улсын хууль тогтоох дээд байгууллагад Монгол Улсын Үндсэн хуулиар олгосон бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Түүнчлэн Ардын Их Хурлын хуралдааны чөлөө цагт түүнд дарга оруулан батлуулахаар Ерөнхий сайдыг томилох буюу чөлөөлнө.

3. БНМАУ-ын Засгийн газрын бүрэн эрх Улсын Их Хурлаас шинэ Засгийн газар байгуулах хүртэл үргэлжлэх бөгөөд энэ хугацаанд Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

*Хөйрдүгээр зүйл.* Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхнийг хэрэгжүүлэх

1. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Ерөнхийлөгчийг сонгож тангараг өргөх хүртэл хугацаанд мөнхүү Үндсэн хуульд заасан Ерөнхийлөгчийн бүрэн эрхнийг БНМАУ-ын анхны Ерөнхийлөгч хэрэгжүүлнэ. Монгол Улсын Үндсэн хуулийг дагаж мөрдсөн өдрөөс эхлэн Ерөнхийлөгчийг Монгол Улсын Ерөнхийлөгч гэж нэрлэнэ.

2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг 1993 оны зургадугаар сард багтаан явуулна.

*Гуравдугаар зүйл.* Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх (шүүх, прокурорын байгууллагыг шинэчлэн байгуулах)

1. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Шүүхийн ерөнхий зөвлөл байгуулагдаж, зохих шатны шүүгчдийг Монгол Улсын Ерөнхийлөгч томилж хүртэл бүх шатны шүүгч, ардын төлөөлөгчид бүрэн эрхээ Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн хуулийн дагуу хэрэгжүүлнэ.

2. Монгол Улсын прокурорын байгууллагын тухай хууль батлан гаргаж Ерөнхийлөгч Улсын Ерөнхий прокурорыг томилж хүртэл хугацаанд БНМАУ-ын Ардын Их Хурлаас томилсон Ерөнхий прокурор, түүний харьяа прокурорууд бүрэн эрхээ Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн хуулийн дагуу хэрэгжүүлнэ.

3. Монгол Улсын Үндсэн хуульд заасан үндэслэлийн дагуу шүүх, прокурорын байгууллагын тогтолцоог шинэчлэх ажлыг 1993 онд багтаан хийж гүйцэтгэнэ.

4. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцгийг энэ тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш гуч хоногийн дотор байгуулна.

*Дөрөвдүгээр зүйл.* Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай Монгол Улсын Үндсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэх

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгуулах, Засаг даргыг томилж хүртэл зохих шатны

Ардын Хурал, түүний Тэргүүлэгчид, гүйцэтгэх захиргаа, тэдгээрийн салбар байгууллагууд бүрэн эрхээ тус тусын Хурлын тухай хууль болон холбогдох бусад хуулийн дагуу хэрэгжүүлэх.

2. Монгол Улсын Үндсэн хуульд эвэсний дагуу нутгийн өөрөө удирдах байгууллагуудыг байгуулах, зарим аймгийн нутаг дэвсгэрт байгаа орон нутгийн харьяалалтай хот, өөр сумын нутаг дэвсгэрт байгаа хөрсө, районьг захив аймаг, суманд нэгтгэн харьяалуулах, нийслэлийн районуудыг татан буулагаж, дүүрэг, хөрсө, хөдсөд баг байгуулах ажлыг 1952 онд багтаан тус тус хийж гүйцэтгэнэ.

3. Хот, тосгоны эрх зүйн үндсийг хуулиар тогтоож, түүний дагуу тэдгээрийн өөрийн удирдлагыг зохион байгуулах хүртэл Дархан, Чойр, Эрдэнэт хот одоогийн нутаг дэвсгэртээ аймагтай адилсах эвсаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалттай байна.

*Төвлөлтөөр зүйл.* Хууль тогтоомжийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн шинэчлэх

1. Монгол Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр болох хүртэл дагаж мөрдөж ирсэн бүх хуулийг мөнхүү Үндсэн хуульд харилдахгүй Сед цаашид хүчин төгөлдөр дагаж мөрдөнө.

2. Гагцхүү хуулиар зохицуулж байхлар Монгол Улсын Үндсэн хуульд эвэсэн харилцааг тэр тухай шинэ хууль батлан гаргах хүртэл хугацаанд уул харилцааг зохицуулж ирсэн хууль, эрх зүйн бусад актын заалтаар зохицуулна. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуульд эвэсэн хуулиудыг Улсын Бага Хурлаас тогтоосон хувиарийн дагуу 1953 онд багтаан батлан гаргана.

3. Монгол Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр болсон өдөрөө эхлэн мөнхүү Үндсэн хуульд хариласан хууль болон эрх зүйн бүх акт, тэдгээрийн заалтыг хүчлнгүй болсонд тооцно.

4. Хууль тогтоомжийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн бүрэн шинэчлэх ажлыг 1956 онд багтаан хийж дуусгана.

*Зургадугаар зүйл.* Монгол Улсын Үндсэн хууль ба Монгол улсын олон улсын гэрээ

1. Монгол Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр болох хүртэл даган мөрдөж ирсэн бөгөөд мөнхүү Үндсэн хуульд харилдахгүй БНМАУ-ын олон улсын гэрээг Монгол улс цаашид нэгэн адил дагаж мөрдөнө.

2. Монгол Улсын Үндсэн хуульд харшлаагүй БНМАУ-ын олон улсын гэрээ бусад хуулийн заалттай зөрчилдсөн тохиолдолд мөнхүү олон улсын гэрээний заалтыг баримтлана.

3. БНМАУ-ын олон улсын гэрээ буюу түүний заалтууд Монгол Улсын Үндсэн хуульд ийцүүлэх асуудлыг олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, тухайн гэрээнд заасан болзол, журмын дагуу 1993 онд багтаан шийдвэрлэнэ.

*Долдугаар зүйл. Монгол Улсын Үндсэн хууль ба хүний эрх*

1. Монгол Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр болох өдөр БНМАУ-ын харьяат байсан бүх хүн Монгол Улсын харьяат хэвээр байна.

2. Монгол Улсын иргэн харьяатаас гэрэх, гадаадын иргэн, харьяалаагүй хүнийг Монгол Улсын харьяат болгох асуудлыг холбогдох хууль нь шинэчлэгдэх хүртэл Монгол Улсын Үндсэн хуулийн зарчмын үндэслэлийг баримтлан, одоо дагаж мөрдөж байгаа «БНМАУ-ын Харьяатын тухай хууль», «БНМАУ-д байгаа гадаадын иргэдийн эрх, үүргийн тухай хууль»-ийн дагуу шийдвэрлэнэ.

3. Монгол Улсын Үндсэн хуульд тодорхойлсон хүний эрхийг дордуулсан заалт Сүтэй БНМАУ-ын хууль болон олон улсын гэрээ, тэдгээрийн заалтыг мөнхүү Үндсэн хууль хүчин төгөлдөр болсноос эхлэн хэргэлэхийг хориглоно. Монгол Улсын Үндсэн хуульд харшлаагүй Монгол Улсын хууль ба олон улсын гэрээний хүний эрхийн талаархи заалт зөрчилдөөл уул гэрээний заалтыг баримтлана.

*Наймдугаар зүйл. Бусад үндэслэл*

1. Монгол Улсын Төрийн дуулалын үг, амыг Улсын Бага Хурал 1992 оны долдугаар сарын 10-нөөс өмнө батлах бөгөөд тийнхүү батлах хүртэл эдүгээ өгшиглүүдэж байгаа Төрийн дуулалын үг, амыг хэвээр хэрэглэнэ.

2. Монгол Улсын Төрийн сүлд, туг, далбаа, тамгыг Монгол Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн харгалзах бөгөөд харин төрийн төв, орон нутгийн байгууллагуудын тамга, тэмдэг зэргийг шинэчлэх ажлыг тухайн байгууллагын шинэчлэлттэй уялдуулан тохиох үе шаттайгаар хийж гүйцэтгэхийг Засгийн газар эрхэлнэ.

3. Монгол Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн «БНМАУ-ын» гэсэн хэлг бүхий төрийн бүх байгууллаага «Монгол Улсын...» гэж нэрлэгдэнэ.

*Есдүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох*

1. Энэхүү Хавсралт хууль Монгол Улсын Үндсэн хуулийнхаа нэгэн адил хүчинтэй.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт хуулийг 1992 оны хоёрдугаар сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрднө.

3. Монгол Улсын Үндсэн хуулийг дагаж мөрдсөн өдөр 1992 оны хоёрдугаар сарын 12-ны өдрөөс эхлэн БНМАУ-ын Үндсэн хууль (1960 оны), түүний Нэмэлтийн тухай хуулийн хамт түүхэн үүргээ гүйцэтгэж халагдсанд тооцно.

## БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН АРДЫН ИХ ХУРАЛ

1992 оны нэгдүгээр  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
хот

09 цаг 38 минут.



БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ХУУЛЬ

1992 оны 1 дүгээр  
сарын 14-ний өдөр

Улаанбаатар  
хот

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН  
ӨДРИЙН ТУХАЙ

Монгол улсын Үндсэн хуулийг 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр баталсантай холбогдуулан БНМАУ-ын Ардын Их Хурлаас ТОГТООХ нь:

*Нэгдүгээр зүйл.* Монгол улсын Үндсэн хуулийн өдрийг жил бүрийн 1 дүгээр сарын 13-нд тэмдэглэж байхаар тогтоосугай.

*Хоёрдугаар зүйл.* Монгол улсын Үндсэн хуулийн уг зхийг нотлох, Төрийн сүлд, далбааны зхийг эзлэх ёслолыг 1992 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр Ардын Их Хурлын танхимд зохион явуулсугай.

Дарга

Ж. УРТНАСАН

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БАТЛАМЖ**

1992 оны 2 дугаар

Дугаар 1

Улаанбаатар

сарын 6-ны өдөр

хот

**ХУУЛЬ БАТЛАМЖЛАХ ТУХАЙ**

Улсын Бага Хурлаас баталсан БНМАУ-ын 1992 оны төсвийн тухай хуулийг зөвшөөрөн батламжиласугай.

**Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч**

**П. ОЧИРБАТ**

## БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ХУУЛЬ

1992 оны 1 дүгээр  
сарын 30-ны өдөр

Улаанбаатар  
хот

### БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН 1992 ОНЫ УЛСЫН ТӨСВИЙН ТУХАЙ

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газраас боловсруулсан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын 1992 оны улсын төсвийн төсвийг хэвлэцээд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үйлсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийг үндэслэн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хурлаас **ТОГТООХ нь:**

1. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын 1992 оны улсын төсвийн орлогыг 5005370,7 мянган төгрөгөөс доошгүй, зарлагыг 7405370,7 мянган төгрөгөөс дээшгүй байхаар батадсугай.

2. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт тэгшитгэх болон орон нутгийн төсвөөс улсын төсөвт татан авах хөрөнгийн хэмжээг анмаг, хот тус бүрээр дор дурдсанаар тогтоосугай:

(мянган төгрөгөөр)

№	Аймаг, хотын нар	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт тэгшитгэх хөрөнгө	Орон нутгийн төсвөөс улсын төсөвт татан авах хөрөнгө
1.	Архангай	108848,0	
2.	Баян-Өлгий	68025,8	
3.	Баянхонгор	61871,2	
4.	Булган	42231,5	
5.	Говь-Алтай	75867,2	
6.	Дорноговь	58420,1	
7.	Дорнод	15421,4	
8.	Дундговь	50530,9	
9.	Завхан	86244,4	
10.	Өвөрхангай	60098,3	

11. Өмнөговь	56169,2	
12. Сүхбаатар	59431,8	
13. Сэлэнгэ	10583,3	
14. Төв	62819,6	
15. Увс	59082,6	
16. Ховд	68700,4	
17. Хөвсгөл	86349,0	
18. Хэнтий	46808,6	
19. Дархан	—	34669,8
20. Улаанбаатар	—	51075,9
21. Эрдэнэт	—	—
22. Чойр	24312,9	

БНМАУ-ын Бага Хурлын  
дэргэ

Р. ГОНЧЫГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын  
парийн бичгийн дэргэ

Б. ЧИМИД

БҮГД НАВРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
АРДЫН ИХ ХУРАЛЫН ТОГТООЛ

1991 оны 11 дүгээр

Дугаар 01

Улаанбаатар

сарын 11-ний өдөр

ХЭГ

БНМАУ-ЫН АРДЫН ИХ ХУРАЛЫН ДЕПУТАТЫН  
БҮРЭН ЭРХИЙГ ДУУСГАВАР БОЛСОНД  
ТООЦОХ ТУХАЙ

БНМАУ-ын Депутатын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, БНМАУ-ын Ардын Хурлын депутатуудын сонгуулийн хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг үндэслэн БНМАУ-ын Ардын Их Хурлаас ТОГТООХ нь:

Ардын Их Хурлын 5 дугаар тойргийн депутат Д. Ганболд Засгийн газрын тэргүүн шадар сайдаар, 41 дүгээр тойргийн депутат Д. Дорангжав Засгийн газрын шадар сайдаар, 169 дүгээр тойргийн депутат Ш. Жадамбаа Батлан хөмгөөлэхийн сайдаар тогсон томилгодож үүрэгт ажилдаа өрсөн тул Д. Ганболд, Д. Дорангжав, Ш. Жадамбаа нарын Ардын Их Хурлын депутатын бүрэн эрхийг 1990 оны 10 дугаар сарын 4-ний өдрөөр, Ардын Их Хурлын 19 дүгээр тойргийн депутат Д. Дамдинг сонгогчид нь огцруулсан тул Ардын Их Хурлын депутатын бүрэн эрхийг 1991 оны 5 дугаар сарын 12-ны өдрөөр тус тус дуусгагар болсонд тооцугай.

Дарга

Ж. ГОМБОЖАВ

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
АРДЫН ИХ ХУРАЛЫН ТОГТООЛ

1991 оны 11 дүгээр  
сарын 11-ний өдөр

Дугаар 03

Улаанбаатар  
хот

БНМАУ-ЫН АРДЫН ИХ ХУРАЛЫН ДЕПУТАТЫН  
БҮРЭН ЭРХИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ

БНМАУ-ын Ардын Их Хурлын депутатуудын бүрэн эрхийн асуудал эрхлэх байнгын комиссын нэлгээнийг хэлэлцүүд БНМАУ-ын Ардын Их Хурлаас ТОГТООХ нь:

Ардын Их Хурлын 12 дахь удаагийн сонгуулийн 5, 8, 19, 36, 41, 147, 151, 169, 278, 289, 330, 351, 353, 358, 375 дугаар тойрогт Ардын Их Хурлын депутатаар сонгогдсон Надегийн Гаравсүрэн, Содовдалайн Ендонцсо, Бат-Очирын Батсайхан, Рэнцэнзорлогийн Ендондэмсэрэл, Нямэхийн Пүрэвдорж, Лувсандагмын Амарсацаа, Бат-Өлзийн Аагаа, Бадамын Шагдар, Доржийн Мсондой, Гүррагчаагийн Нороврагчаа, Сандагийн Гончиг, Бувицын Мунгөн, Балжингийн Шинэн, Бадамын Жанцансамбуу, Доржготовын Баяндалай нарын Ардын Их Хурлын депутатын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсүгэй.

Дарга

Ж. ГОМБОЖАВ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
АРДЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

1991 оны 11 дүгээр

Дугаар 05

Улаанбаатар

сарын 11-ний өдөр

ХТ

**БНМАУ-ЫН АРДЫН ИХ ХУРЛЫН  
ДАРГЫГ СОНГОХ ТУХАЙ**

БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийн дөрөв-дүгээр зүйлийг үндэслэн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

БНМАУ-ын Ардын Их Хурлын даргаар 318 дугаар тойргийн депутат **Жамбаадоржийн Уртнасанг** сонгосугай.

Дарга

**Ж. ГОМБОЖАВ**

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
АРДЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

1991 оны 11 дүгээр

Дугаар 06

Улаанбаатар

сарын 11-ний өдөр

ХТ

**БНМАУ-ЫН АРДЫН ИХ ХУРЛЫН ОРЛОГЧ  
ДАРГА НАРЫГ СОНГОХ ТУХАЙ**

БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийн дөрөв-дүгээр зүйлийг үндэслэн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

БНМАУ-ын Ардын Их Хурлын орлогч даргаар 43 дугаар тойргийн депутат **Нямжавын Батбаяр**, 194 дүгээр тойргийн

депутат Төмөрийн Жагай, 144 дүгээр тойргийн депутат Цогт-Очирын Лоохууз, 278 дугаар тойргийн депутат Доржийн Мсондой нарыг тус тус сонгосугай.

Дарга

Ж. ГОМБОЖАВ

БҮГД НАВРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
АРДЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1991 оны 11 дүгээр

Дугаар 07

Улаанбаатар

сарын 11-ний өдөр

хөт

БНМАУ-ЫН АРДЫН ИХ ХУРЛЫН  
ДАРГЫГ ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийн дөрөв дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн БНМАУ-ын Ардын Их Хурлаас ТОГТООХ нь:

БНМАУ-ын Ардын Их Хурлын даргаас 326 дугаар тойргийн депутат Жамбын Гомбожавыг чөлөөлсүгэй.

Дарга

Ж. УРТНАСАН



**БҮГД НАВРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
АРДЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

1991 оны 11 дугаар

Дугаар 08

Улаанбаатар

сарын 11-ний өдөр

хот

**БНМАУ-ЫН АРДЫН ИХ ХУРЛЫН ОРЛОГЧ  
ДАРГА НАРЫГ ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ**

БНМАУ-ын Үндсэн хуулийн цэмээлийн тухай хуулийн дөрөвдүгээр зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн БНМАУ-ын Ардын Их Хурлаас **ТОГТООХ нь:**

БНМАУ-ын Ардын Их Хурлын орлогч даргаас 55 дугаар тойргийн депутат Цохногийн Адьясүрэн, 22 дугаар тойргийн депутат Луусамдамбын Дашням, 216 дугаар тойргийн депутат Ойдовын Долгорсүрэн, 83 дугаар тойргийн депутат Хымышийн Хүжэй нарыг тус тус чөлөөлсүгэй.

Дарга

**Ж. УРТНАСАН**

**БҮГД НАВРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
АРДЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

1992 оны 1 дугаар

Дугаар 14

Улаанбаатар

сарын 13-ны өдөр

хот

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ  
НИЙТЛЭХ ТУХАЙ**

БНМАУ-ын Ардын Их Хурлаас **ТОГТООХ нь:**

1. Монгол Улсын Үндсэн хуулийн албан ёсны эхийг «Ардын эрх» сонин, «Төрийн мэдээлэл» сэтгүүлд нийтэлж, Монголын

радио, телевизээр дамжуулсугай.

2. «Ардын эрх» сонинд нийтэлсэн эхээс өхний удаад хуулбарлан нийтлэхийг төв, орон нутгийн сонинны газруудад зөвшөөрсугай.

3. Монгол Улсын Үндсэн хуулийг хэвлэн нийтлэх талаар дараахь журам тогтоосугай:

1) гагцхүү Монгол Улсын Их Хурлын эрхлэн хэвлүүлсэн Үндсэн хуулийг албан ёсны хэвлэл болгон нийтээр баримтлана;

2) аливаа байгууллага, сонин, хэвлэлийн газрууд Үндсэн хуулийг хэвлэн нийтлэхийг хүсвэл Улсын Их Хурлын дарга буюу тэд даргын зөвшөөрөл авна.

4. Улсын Их Хурал Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу байгуулагдах зүртэлх хугацаанд энэхүү тогтоолд заасан журмыг Ардын Их Хурал, түүний чөлөө цагт Улсын Бага Хурал эрхлэн хэрэгжүүлж байхаар тогтоосугай.

Дарга  
Орлогч дарга

Ж. УРТНАСАН  
Н. БАТБАЯР  
Т. ЖАГАЙ  
Ц. ЛООХУУЗ  
Д. МООНДОЙ

## БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН АРДЫН ИХ ХУРАЛЫН ТОГТООЛ

1992 оны 1 дүгээр  
сарын 23-ны өдөр

Дугаар 17

Улаанбаатар  
хот

### ЕРӨНХИЙ САЙДАД ИТГЭЛ ХҮЛЭЭЛГЭХ ТУХАЙ

БНМАУ-ын Ардын Их Хурлын II хуралдааны санал хураах комиссын 1992 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 2 дугаар тогтоолыг үндэслэн БНМАУ-ын Ардын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. БНМАУ-ын Ардын Их Хурлын II хуралдааны санал хураах комиссын тогтоолыг баталсугай.

2. БНМАУ-ын Ерөнхий сайдад итгэл хүлээвэгж байгаагаа илэрхийлсүгэй.

Ардын Их Хурлын дарга  
Орхон дарга

Ж. УРТНАСАН  
Н. БАТБАЯР  
Т. ЖАГАН  
Ц. ЛООХУУЗ  
Д. МООНДОЙ

БҮГД НАПРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
АРДЫН ИХ ХУРАЛЫН ТОГТООЛ

1992 оны 1 дүгээр

Дүгээр 21

Улаанбаатар

сарын 24-ний өдөр

хот

ЗАРИМ ХҮНИЙГ БНМАУ-ЫН БАГА ХУРАЛЫН  
ГИШҮҮНИЙГ ҮҮРЭГТ АЖЛААС ЧӨЛӨӨЛӨХ  
ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлын гишүүний үүрэгт ажлаас чөлөөлж өгөхийг хүссэн хувийн өргөдөл, МАХН-ын оруулсан санжамыг харгалзан БНМАУ-ын Бага Хурлын тухай хуулийн 19-р зүйлийн 2 дугаар заалтыг үндэслэн БНМАУ-ын Ардын Их Хурлаас ТОГТООХ нь:

Санжаагийн Баяр, Гүнсэнгийн Ахагважав, Дүгэрижавын Маам, Логийн Цог нарыг БНМАУ-ын Бага Хурлын гишүүний үүрэгт ажлаас өөрсдийн хүсэлт, МАХН-ын саналаар тус тус чөлөөлсүгэй.

Ардын Их Хурлын дарга  
Орхон дарга

Ж. УРТНАСАН  
Н. БАТБАЯР  
Т. ЖАГАН  
Ц. ЛООХУУЗ  
Д. МООНДОЙ,

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
АРДЫН ИХ ХУРАЛЫН ТОГТООЛ

1992 оны 1 дүгээр  
сарын 25-ны өдөр

Дугаар 24

Улаанбаатар  
хот

БНМАУ-ЫН БАГА ХУРАЛЫН ЗАРИМ  
ГИШҮҮНИЙГ НӨХӨН СОНГОХ ТУХАЙ

БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хууль, БНМАУ-ын Ардын Их Хурлын хоёрдугаар хуралдааны дэглээсэн журмын дагуу санал нууцаар хураасан дүнгийн тухай санал хураах комиссын тогтоолыг үндэслэн БНМАУ-ын Ардын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

БНМАУ-ын Бага Хурлын гишүүнээр дараахь хүмүүсийг сонгох сонгосугай:

НЭГ. МАХН-д хуваариллагдсан БНМАУ-ын Бага Хурлын гишүүдийн мандатал:

1. А. Баяндалай
2. Ж. Бямбадорж
3. Н. Ганбямба
4. Д. Дэмбарал
5. Ж. Норовсамбуу

ХОЕР. МоАН-д хуваариллагдсан БНМАУ-ын Бага Хурлын гишүүний мандатал:

1. Ц. Энхбат
2. Б. Пүрэндорж

ГУРАВ. МҮДН-д хуваариллагдсан БНМАУ-ын Бага Хурлын гишүүний мандатал:

1. Б. Гунджадам

Дарга  
Оросын дарга

Ж. УРТНАСАН  
Н. БАТБАЯР  
Т. ЖАГАЙ  
Ц. АООХУУЗ  
Д. МООНДСИ

БҮГД НАЯРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
АРДЫН ИХ ХУРАЛЫН ТОГТООЛ

1992 оны 1 дугаар

Улаанбаатар

Дугаар 25

сарын 25-ны өдөр

хот

БНМАУ-ЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ  
АЖИЛААГААНЫ ТУХАЙ

Засгийн газрын үйл ажиллагаа, дотоод, гадаад бодлогын үндсэн асуудлын талаар Ерөнхий сайд Д. Бямбасүрэнгийн тавьсан нэгтгэлийг БНМАУ-ын Ардын Их Хурлын II хуралдаанаар хэлэлцээд **ТЭМДЭГЛЭХ** нь:

Засгийн газрыг олон ниймн төлөөлөгчдийн оролцоотойгоор эмгэцэн байгуулж ардчилал, шинэчлэлийг гүйцэтгирүүлэх, улс орны эдийн засгийг зах зээлийн харилцаанд шилжүүлэх, монгол улсын гадаад харилцааг дэлхий дахины нийтдэг хандлагад зохицуулан өргөтгөх талаар явуулсан үйл ажиллагааны үндсэн чиглэлийг зүйтэй гэж үзэж байна.

Гэлч улс орны эдийн засаг, нийгмийн амьдралыг удирдан зохион байгуулах үйл ажиллагаанд Засгийн газраас алдаа, дутагдал цөөнгүй гаргасан байна.

Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үед нийгмийн амьдралд тохиолдож байгаа сөрөг үзэгдэлээс ард түмнээ бололцоотой хэмжээгээр хамгаалах дорвитой арга хэмжээ авч чадсангүй.

Эдийн засгийн нооц бололцоог шилжих дийлэлж, үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх, барааны хомсдол, эдийн засгийн хямралыг багасгаж, тэнцвэржүүлэх ач холбогдол бүхий төргүүлэх салбар, үйлдвэрлэлийг хөгжүүлэх асгамг зохион байгуулахад цаг алдаж улс орны хөгжлийн суурь салбар болсон хөдөө аж ахуйд тавих эрхшээлийг суаруулсан байна.

Эдийн засгийг зах зээлийн харилцаанд шилжүүлж байгаа энэ үед албан татвар, үнэ, цаалин хөлс, зээл, валют санхүүгийн бодлогыг хэрэгжүүлэхэд тавих хяналт, хүч, нөлөө дутсан нь улс орны эдийн засгийн чадавхийг доройтуулж, соёл боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны салбарын хөгжилд муугаар нөлөөлжээ.

Улсын алтны ба валютын сангийн зарцуулаалтад хяналт тавьж валютын нөөцийг тодорхой түвшинд барьж байх төрийн бодлогод ноцтой алдаа гаргасан нь импортын хэмжээ буурах, төсвийн алдаагаа өсч, гадаад төлбөрийн чадвар алдагдахад хүргэжээ.

Засгийн газар олон түмний гүнд орол ажиллаах, гаргасан шийдвэрээ тэдэнд хүргэж сурталчлах, биелэлтэд нь хяналт тавих ажлыг зохих ёсоор зохион байгуулаагүйгээс зарим шийдвэр нь тэр бүр зохих үр дүнгээ өгсөнгүй.

Олон улсын харилцааны шинэ нөхцөлд гадаад худалдаа, хамтын ажиллагааг үр ашигтай зохицуулах, шинэ зах зээл олж экспортын уламжлалт барааг нийлүүлэхэд цаг хугацаа алдаж байв.

Төрийн захиргааны бүх шатны байгууллагын материалаар бааз, боловсон хүчин бодон сахнага, дэг журмыг бэхжүүлэх, төр, засгийн албанд үнэнч шударга, чадвартай хүмүүсийг ажилдуулах, нийгмийн хэв журам сахиулах талаар зохиосон ажлын өүсийн үр дүн хангалтгүй байсны улмаас эмх замбараагүй байдал газар авах, гэмт хэрэг, зөрчил өсөх явдлыг цаг тухайд нь таслан зогсоож, бууруулж чадаагүй байна.

### БНМАУ-ын Ардын Их Хурлаас ТОГТООХ нь:

Нэг, Ойрын хугацаанд дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг БНМАУ-ын Засгийн газарт даалгасугай:

1) эдийн засаг, нийгмийн хүрээнд хийж буй шинэчлэлтийг гүнзгийрүүлэх, ажлын харилцаага, сахнага, дэг журам, зохион байгуулалт, нөхцөлийг сайжруулан, нөөц боловцоог дээд зэргээр дайчлах үндсэн дээр эдийн засгийн бууралтыг зогсоож хямралыг тогтоон барих, үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээг нэмэгдүүлэхэд нийтийн хүч, анхаарлыг төвлөрүүлэх;

2) эдийн засгийг зах зээлийн харилцаанд шилжүүлэх талаар БНМАУ-ын Засгийн газар, Олон улсын валютын сангийн хооронд тохиролцсон дөтөлбөрийг чанд мөрдөж хэрэгжүүлэх;

3) чөлөөт үнэ хэрэгсэл хүрвэг өргөтгөж, албан татвар, цаалин, үнэ, зээлийн бодлогыг эдийн засгийн бодит амьдралтай нягт уялдуулахын хамт хүү амын орлого багатай хэсгийн амьжирганы эх үүсвэрийг баталгаатай болгох;

4) хөдөө аж ахуйг хөгжүүлэхэд онцгой анхаарч, тэл хүлээн авах, хягрын тариалааг, ургац хураалт зэрэг цаг үеийн ажлын бэлтгэлийг өртнээс хангаж, түмэн, өрчим хүч, шатахуун,

техник, сэлбэг хэрэгсэл, өвс тэжээлийн хангамж, улсын нөөцийг нэмэгдүүлэх;

5) БНМАУ-ын хууль тогтоомж болон гаргасан шийдвэрийнхээ биелэлтийг хангахад онцгой анхаарч, улсын хяналтын албыг бэхжүүлэх;

6) БНМАУ-ын Засгийн газрын үйл ажиллагаа, дотоод, гадаад бодлогын үндсэн асуудлын талаар БНМАУ-ын Ерөнхий сайд Д. Бямбасүрэнгийн илтгэлийг хэлэлцэх явцад Ардын Их Хурлын депутатууд болон хөдөлмөрчдөөс гаргасан санал шүүмжлэлийг хэрэгжүүлэх.

Хоёр, Алт, валютын арилжааны алдагдлын тухай асуудлыг хуулийн байгууллагаас цаашид нягтлан шаалгахад шаардлагатай дэмжээг туслаацаа үзүүлж, алт, валютын арилжааны алдагдлыг нөхөх арга хэмжээ авч ажиллахыг БНМАУ-ын Бага Хурал, Засгийн газарт даалгасугай.

Гурав, БНМАУ-ын Ардын Их Хурлаас итгэл хүлээлгэсэн Засгийн газраас авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг тууштай дэмжинд, ажил хэрэг болгоход хүч чармайлтаа дайчлан ажиллахыг БНМАУ-ын нийт байгууллага, иргэдэд уриалсугай.

Ардын Их Хурлын дарга  
Орлогч дарга

Ж. УРТНАСАН  
Н. БАТБАЯР  
Т. ЖАГАЙ  
Ц. ЛООХУУЗ  
Д. МООНДОП.

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
АРДЫН ИХ ХУРЫН ТОГТООЛ

1992 оны 1 дүгээр  
ардын 25-ны өдөр

Дугаар 26

Улаанбаатар  
хот

БНМАУ-ЫН БАГА ХУРЫН ҮЙЛ  
АЖИЛААГААНЫ ТУХАЙ

«БНМАУ-ын Бага Хурлын үйл ажиллагааны тайлан, хууль

тогтоох ажлыг сайжруулах зорилтын тухай» нэгдэврийг хэлвэл үзвэл БНМАУ-ын Ардын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. БНМАУ-ын Бага Хурлын үйл ажиллагааны тайлан, хууль тогтоох ажлыг сайжруулах зорилтыг зүйтэй гэж үзвэл, Монгол Улсын Үндсэн хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах иж бүрэн арга хэмжээний хөтөлбөр боловсруулан ажиглахыг Улсын Бага Хуралд даалгасугай.

2. Дээрхи арга хэмжээний хүрээнд Ардын Их Хурлын II хуралдааны явцад депутатуудаас гаргасан санаал, дүгнэлтийн гаргалзан дараахь хуулийн төслүүдийг нэн даруй боловсруулж батлан гаргах нь зүйтэй гэж үзсүгэй:

а) Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль, Улсын Их Хурлын тухай хууль, Нутгийн захиргаа, өөрөө удирдах ёсны тухай хууль, Шүүхийн байгууламжийн тухай хууль, Үндсэн хуулийн цэцгийн тухай хуулийг 1992 оны 6 дугаар сарын 1-ний дотор;

б) Ерөнхийлөгчийн тухай хууль, Засгийн газрын тухай хууль, Улсын Их Хурлын гишүүний тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Иргэдийн шашин шүтэх эрх мэдлийн тухай хууль, Цэргийн үүргийн тухай хууль (Баулан хамгаалах тухай хууль), Төрийн бөөгэ тэмдгийн тухай хууль, Прокурорын байгууллаагын тухай хуулийг 1992 оны 7 дугаар сарын 1-ний дотор.

3. БНМАУ-ын Засгийн газрын тайланг хэлэлцэхэд гарсан санаа, дүгнэлтийн дагуу Монгол банкны үйл ажиллагаанд дүгнэлт хийж, цаашид авах арга хэмжээг Засгийн газартай хамтран ажил хэрэгжүүлсүгэй.

4. Засгийн газрын болон Улсын Бага Хурлын тайланг хэлэлцэхэд депутатуудаас гаргасан санаал, дүгнэлтийн дагуу Засгийн газрын болон өрөн нутгийн Ардын Хурлын үйл ажиллагааг чиглүүлэн ажиглахыг Улсын Бага Хуралд даалгасугай.

Ларга  
Орлогч дорно

Ж. УРТНАСАН  
Н. БАТБАЯР  
Т. ЖАГАЙ  
Ц. ЛООХУУЗ  
Д. МООНДОЙ,



БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
БАГА ХУРАЛЫН ТОГТООЛ

1992 оны 1 дүгээр

Улаанбаатар

сарын 31-ний өдөр

Дугаар 7

хот

МОНГОЛБАНКНЫ 1992 ОНЫ ОРЛОГО,  
ЗАРЛАГЫН ТӨСВИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хурлаас ТОГ-  
ТООХ нь:

1. Монголбанкны 1992 оны орлогыг 96402,0 мянган, зарлагыг 38532,0 мянган төгрөгөөр тус тус баталсугай.

2. Засгийн газар, Улсын Бага Хурлын хамтарсан комисс томилж Монголбанк байгуулахын өмнөх Улсын Банкны 1990 оны орлого, зарлагын тайлан тэнцвэл дүн шинжилгээ хийлгэж, Монголбанкны 1991 оны тайлан тэнцвийн хамт энэ оны III сард багтаан Улсын Бага Хуралд оруулахыг Засгийн газар (н. Бямбасүрэн), Улсын Бага Хурлын Эдийн засгийн байнгын хороо (н. Энхсайхан)-д даалгасугай.

Дарга

Р. ГОНЧИГДОРЖ

Нарийн бичгийн дарга

Б. ЧИМИД

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
БАГА ХУРЛЫН ТОГТООЛ**

1992 оны 2 дугаар

Улаанбаатар

сарын 1-ний өдөр

Дугаар 8

хот

**УЛСЫН 1990 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН  
ТАЙЛАНГ БАТЛАХ ТУХАЙ**

БНМАУ-ын Бага Хурлаас **ТОГТООХ** нь:

1. БНМАУ-ын 1990 оны нэгдсэн төсвийн орлогыг 6494,2 сая төгрөгөөр, зарлагыг 6812,3 сая төгрөгөөр, төсвийн алдагдлыг 318,1 сая төгрөгөөр тус тус баталсугай.

2. БНМАУ-ын Засгийн газарт даалгах нь:

а) төсвийн жилийн явцад төсвийн зарлага (алдагдал)-ыг хуульд зааснаас хэтрүүлж байсан гажуудамыг зогсоож, төсвийн хуулийг тууштай биелүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авсугай;

б) улсын 1991 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд судалгаа дүгнэлт хийж, төсвийн алдагдлыг нөхөх саналыг хамт энэ оны 5 дугаар сард багтаан Улсын Бага Хуралд оруулсугай.

**Дарга**

**Р. ГОНЧИГДОРЖ**

**Нарийн бичгийн дарга**

**Б. ЧИМИД**

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
БАГА ХУРАЛЫН ТОГТООЛ**

1992 оны 2 дугаар

Дугаар 10

Улаанбаатар

сарын 1-ний өдөр

хот

**БНМАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 1992  
ОНД ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ТУХАЙ**

БНМАУ-ын нийгэм-эдийн засгийн байдал, 1992 онд хөгжүүлэх чиглэлийн тухай Үндэсний хөгжлийн сайд н. Батсуурийн нэлтгэлийг сонсоод БНМАУ-ын Бага Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Засгийн газраас оруулсан БНМАУ-ын эдийн засаг, нийгмийг 1992 онд хөгжүүлэх чиглэлийг үндсэнд нь зүйтэй гэж үзсүгэй.

2. Улсын Бага Хурлаас дэмжсэн Чиглэлийг хэрэгжүүлэх талаар Засгийн газраас авч буй арга хэмжээ, түүний биедэлтэд тогтмоо хиналт тавьж, дэмжлэг туслахаа үзүүлж байхыг Эдийн засгийн бодол Нийгмийн бодлогын байнгын хороод, Улсын Бага Хурлын удирдлагад даалгасугай.

Дарга

**Р. ГОНЧИГДОРЖ**

Нэрийн бичгийн дарга

**Б. ЧИМИД**

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
БАГА ХУРАЛЫН ТОГТООЛ

1992 оны 2 дугаар

Дугаар 11

Улаанбаатар

сарын 1-ний өдөр

ХОТ

ЗАРИМ ГАЗАР НУТГИЙГ УЛСЫН ТУСГАЙ  
ХАМГААЛАЛТАД АВАХЫГ ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

Байгалийн бүс, бүслүүрийн үндсэн төрхийг төлөөлөх өвөрмөц тогтоцтой, ховор амьтан, ургамал бүхий дор дурдсан газар нутгийг улсын тусгай хамгааламттай болгохыг Засгийн газарт зөвшөөрсүгэй:

- 1) Алатайн өвөр голын Ээж хайрхан уул;
- 2) Хэрлэн, Онон, Туул, Минж голуудын эх авсан Хэвтийн нурууны төв хэсэг;
- 3) Мэнэнгийн тал, Лагийн хоолойг хамарсан монголын Дорнодын талын хэсэг;
- 4) Монгол дагуурын хэсэг;
- 5) Дэгээ, Номръгийн голын сав газар;
- 6) Отгонтангар уул;
- 7) Ховсгол нуур, түүний сав газар;
- 8) Хүйсийн Найман нуур.

Дарга

Р. ГОНЧИГДОРЖ

Нарийн бичгийн дарга

Б. ЧИМНД

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
БАГА ХУРЫЛЫН ТОГТООЛ

1992 оны 2 дугаар

Дугаар 14

Улаанбаатар

сарын 2-ны өдөр

хот

ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

1. «Монгол Улсын Үндсэн хуулийг бүрнээ дагаж мөрдөх ажлыг зохион байгуулах, Ардын Их Хурлын хоёрдугаар хуралдааны шийдвэрийг биелүүлэх талаар нэн тэргүүнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө»-г хавсралтын ёсоор баталсугай.

2. Уг төлөвлөгөөг биелүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажлаахыг Улсын Бага Хурлын байнгын хороод, Улсын дээд шүүх, Улсын прокурорын газар, Засгийн газар, яам, тусгай газрууд, аймаг, хотын Ардын Хурал, тэдгээрийн гүйцэтгэх захиргаалад даалгасугай.

3. Төлөвлөгөөний биелэлтийг Улсын Бага Хурлын чуулганаар энэ оны 6 дугаар сард хявалцэхээр тогтоосугай.

Дарга

Р. ГОНЧИГДОРЖ

Нарийн бичгийн дарга

Б. ЧИМИД

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙГ БҮРНЭЭ ДАГАЖ МӨРДӨХ  
АЖЛЫГ ЭОХИОН БАЙГУУЛАХ, АИХ-ын II ХУРАЛДААНЫ  
ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭХ ТАЛААР НЭН ТЭРГҮҮНД  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Алч гэрэгжүүлэх арга хэмжээ	хугацаа	Хэрэгжих байгууллага	Биеэлэлт хийхэд тавьж, дүгнэх байгууллага, албан тушаалтан
		2	3	4

Нэг. Монгол Улсын Үндсэн хууль, түүний хэсэрлэлт хууль, АИХ-ын II хурал-даны шийдвэрийг мөд нийтэд тайлбарын төшүүлэх, хуулийн тайлбар гаргах талаар

1. Монгол Улсын Үндсэн хууль, түүний хэсэрлэлт хууль, АИХ-ын II хурал-даны шийдвэрийг мөд нийтэд тайлбарын төшүүлэх, хуулийн тайлбар гаргах талаар  
1992 оны Улсын Бага Хур-УБХ  
11-III сард  
Улсын Бага Хур-УБХ  
амн Тамгын газар Б. Цемид
2. Монгол Улсын Үндсэн хууль, АИХ-ын II хурал-даны шийдвэрийг хүн амд тайлбарлан таниулах II сараас тусгай хөтөлбөрийн дагуу нийтлэл, хэвлүүлэг зохион байгуулах, энэ ажлыг эрхлэх комисс байгуулах ажлаагуулах  
Хууль зүйн нам, УБХ  
Төр, нийгэм суд-К. Зорьжсан  
ААМН академн,  
Төр, засгийн хэв-  
дэл, мэдээллийн  
байгууллагууд
3. Монгол Улсын Үндсэн хууль, АИХ-ын II хурал-даны шийдвэрийн дагуу тус орны нийгэм-уас төрийн амьдралд хийгдэж буй шинэчлэлт, өөрчлөлтийг гэдээл оруулах мэдээлж сурталчлах арга хэмжээ анх  
Гадаад харилцаа-  
ны нам,  
«МОНЦАМЭ»  
МОНГО-  
лын радио, теле-  
виз, Монголын  
инхэйшан. Най-

4. Монгол Улсын Үндсэн хууль, АИХ-ын II хурал-  
даны шийдвэрийг тайлбарлан таниулах ажлыг нэгд-  
сэн удирдамжаар орон нутагт зохион байгуулах  
(УБХ-ын гишүүд, АИХ-ын депутатууд, Засгийн  
газар, Хуулийн төв байгууллагуудын удирдах ажилва-  
тан, эрдэм шинжилгээний ажилтанууд, хуульчдыг  
оролцуулан)
5. Монгол Улсын Үндсэн хуулийг тайлбарласан лекц,  
ирлэгийн сэдэв, авалх материал боловсруулагч гаргах II-IV сард  
ХЗЯ, ШУА, Төр, УБХ  
индигм судлаачин Б. Чимид  
академин, Хууль  
зүйн сургаалт, эр-  
дэм шинжилгээл-  
ийн хүрээлэн
6. Монгол Улсын Үндсэн хуулийг судлах инээдлийн  
программыг боловсруулан их, дээд, тусгай мэргэж-  
лийн болон ерөнхий боловсролын дунд сургуулиу-  
дэд эзлэх арга хэмжээ эвх  
1991-1992 Боловсролын яам Засгийн газар  
оним ажчаа холбогдох бусад Д. Дорлигжав  
лийн жи- байгуулагча  
лийн II ха-  
гасаас эх-  
лэх
7. Монгол Улсын Үндсэн хуулийг өөрийн салбарын  
ошдогтой холбон системийнхээ хэмжээнд тайлбар-  
лан таниулах, албан хаагчдын сургаал зохион бай-  
гуулах  
Нийт яам, тусгай Засгийн газар  
Д. Дорлигжав
8. Монгол Улсын Үндсэн хуулийн талаар онол-прак-  
тийн багц хурал зохион байгуулах  
ШУА, төр, ний- УБХ  
гэн судлаачин ака- К. Зардысан  
дмин, МУИС

9. Монгол Улсын Үндсэн хуулийн уас төр, эрх зүйн 1992 оны Улсын Бага Хурал УБХ тийгвэр баатга ашмыг зохион байгуулах Р. Гончигдорж

**Хоёр.** Монгол Улсын Үндсэн хуульд зөвсөн хуулуудыг баталж гаргах, бусад хууль, олон улсын гэрээ, эрх зүйн актыг түүнд нийцүүлэх талаар

10. Монгол Улсын Үндсэн хуульд зөвсөн нэн тэргүүнд 11-VII сард УБХ-ын байнгын УБХ шаардаагатай дархлыг хуулуудыг баталж гаргах. хороод, Засгийн Р. Гончигдорж газар, хоолойгодоо нам, тусгай газар

- 1) Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль
- 2) Нутгийн захиргаа, оороо удирдах ёсны тухай хууль
- 3) Монгол Улсын Их Хурлын тухай хууль
- 4) Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль
- 5) Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
- 6) Монгол Улсын шүүхийн байгууламжийн тухай хууль
- 7) Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн тухай хууль
- 8) Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль
- 9) Монгол улсын прокурорын байгуулагын тухай хууль
- 10) Газрын тухай хууль
- 11) Улсын аюулгүй байдлыг хангах тухай хууль
- 12) Төрийн бэлгэ тэмдгийн тухай хууль
13. Дагал мөрдөж байгаа БНМАУ-ын хууль, эрх зүйн бусад актыг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн омад Улсын Бага Хурал Улсын Бага Хурал УБХ-ын байнгын хороод, Засгийн газар, нам, улсын Р. Гончигдорж хоолой, тусгай газар



12. Монгол Улсын Үндсэн хуульд заагдсан БНМАУ-ын олон улсын гэрээ буюу тэдгэрийн заалтуудыг Монголын Улсын Үндсэн хуульд нийцүүлэх арга хэмжээ авах  
1992—1993 Галдад харилцааны нам, Х.ЗН, холбогдох бусад байгууллагч  
Засгийн газар Д. Бямбасүрэн
13. Улсын Дээд шүүхийн бүтэц хуралын удирдамж, тогтоолуудыг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэх, БНМАУ-ын Шүүхийн байгууламжийн тухай хууль, Эрүүгийн болон Иргэний байцаан шийтгэх хуулиудыг хэрэглэх талаар Улсын дээд шүүхийн тайлбар гаргах  
1992 оны II—III сард  
Улсын Дээд шүүх Улсын Бага Хуралын Хуралын эдийн байнгын хороо Н. Ганбалар
- Гурав, Ардын Их Хурлын II хуралдааныг шийдвэр гарсан санаа шүүмжлэлийн дагуу төр, засгийн байгууллагуудад нэгжиг байгуулах, шийгэм-эдийн засгийн арга хэмжээ авах талаар
14. Монгол Улсын Үндсэн хуулийг хэрэгжүүлэх нэгж буюу арга хэмжээний хөтөлбөр боловсруулах  
1992 оны III сард  
Улсын Бага Хуралын эдийн байнгын хороо, Тагтын газар Р. Гончигдорж
15. Монгол Улсын Их Хуралын гишүүний сонгуулийг явуулах комисс томилон тусгай төлөвлөгөөтэй ажиглах  
1992 оны III—VI сард  
Улсын Бага Хуралын Ерөнхийлөгч Амин Төрийн байгууллаагчын байнгын байнгын хороо И.Х. Хуралын эдийн байнгын хороо Ж. Уртнасан
16. Зарим аймгийн нутаг дэвсгэрт байгаа орон нутгийн хот, өөр сумын нутаг дэвсгэрт байгаа хороо, районийг нэгжиг аймэг, суманд нэгтгэн заръяауулах асуудлыг боловсруулах  
Улсын Бага Хурал оруулан шийдвэрлүүлэх  
1992 оны IV—V сард  
Засгийн газрын орон нутгийн хурал, захиргааны хэлтэс

17. Нутгийн өөрөө удирдах байгууллагуудыг Үндсэн 1992 оны УБХ-ын Төрийн Улсын Бага Хууль зассым дагуу байгуулах арга хэмжээ явах байгууламтын даг байнгын хороо, Р. Гончигдорж Засгийн газрын Засгийн газар Орон нутгийн Хууль Д. Бямбасүрэн рал, захиргааны хэлтэс
18. Аалт, нэлэгтэн аришаагчид өмчлөх ажил үзүүлдэг прокурорын байгуулалтыг шалгаж шийдвэрлэхэд шаардлагатай дэмжлэг тусалцаж үзүүлэх 1992 оны Улсын Бага Хурал Ардын Их Хурал амин Эдийн засгийн байнгын хороо, Засгийн газар
19. Тэтгэврийн, Өмч хувьчлалын, Бэлний, аж ахуйн нэгжийн, Галаныг зэрэг хуульчлал, өөрчлөлт оруулах тухай санал шүүмжлэлийг судалж шийдвэрлэх 1992 оны Улсын Бага Хууль Ардын Их Хурал рал, Засгийн газар Р. Гончигдорж
20. Ардын Их Хуралын II хуралдаанд депутатуудын тавьсан санал, шүүмжлэлийн үндсийг судалж, төр, захиргаа хуулийн болон олон нийтийн байгууллагуудын үйл ажиллагаанд анхаарч хэрэгжүүлэх асуудлыг системчлэн, холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх 1992 оны ШУА, Төр, нийслэл, суллаамын академн, Засгийн газрын төрийн боллого, нийгмийн асуудал судлах төв
21. Эдийн засгийн хямралыг савруулж, түүнийг тогтворжуулах, шийдвэрийг гүнзгийрүүлэх, хүн ам ялангуяа хооногийн хүн амын нийгмийн чухал асуудлуудыг шийдвэрлэх баримт үйлдвэрлэл, халтгайныг нэмэгдүүлэх, санхүүг бэхжүүлэх зэрэг асуудлаар Ардын Их Хуралын II хуралдааны шийдвэр, санал шүүмжлэлийн мөрөөр тусгай төлөвлөгөөтэй, шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлэх 1992 оны Засгийн газар Ардын Их Хурал Хууль хамгаалх даг байгуулалтаг Д. Уртнасан
22. Улсын хяналтын даба, улсын аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч 1992 оны Засгийн газар Д. Бямбасүрэн

23. Монгол Улсын Үндсэн хуулийг хүчин төгөлдөр мөр- 1992 оны Ерөнхийлөгчийн Ерөнхийлөгч  
дөж өздөхтэй холбогдуулан энгэр ёслолын ажиллагааг II сарын Тамгын газар, Зас- П. Очирбат  
12-нд гийн газрын Хэ-  
рэг эрхлэх газар

ЭХЭНОВ БАЙГУУЛАХ

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛЭГЧИЙН ЗАРАГ

1992 оны 1 дүгээр

Улаанбаатар

сарын 24-ний өдөр

Дугаар 1

хот

ЗАСАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ ХӨДӨЛМӨРИЙН  
БАЙГУУЛЛАГЫН ОФИЦЕР, АХЛАГЧДЫН  
ТАНГАРАГ БАТЛАХ ТУХАЙ

БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын  
офицер, ахлагчдын тангаргийг дор дурдсанаар баталсугай.

БНМАУ-ЫН ЗАСАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ  
ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ОФИЦЕР,  
АХЛАГЧДЫН ТАНГАРАГ

БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын  
ажилтан би төрийн хуулиа дээдлэн, гэмт этгээдэд шүүхээс  
оногдуулсан хорих ял эдлүүлэх, тэднийг үйлдсэн гэмт хэрэгт нь  
цээрлүүлэн ойлгуулахын төлөө бүхий л мэдлэг, чадвараа дайч-  
лан, үнэнч шударга ажиллаж, шаардлага гарвал амь биеэ үл  
хайрлахаа эх орон, ард түмэн, төр засагтаа андгайлан тангар-  
галай.

Би энэ тангаргаасад илцвэл төрийн хуулийн хатуу цээр-  
лэл хүлээнэ.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

1992 оны 1 дүгээр

Дугаар 2

Улаанбаатар

сарын 28-ны өдөр

ХОТ

**ЛУВСАНДОРЖИЙН ДАВААГИВИЙГ ЭЛЧИН  
САЙДААР ТОМИЛОХ ТУХАЙ**

Лувсандоржийн Даваагивийг Бүгд Найрамдах Монгол Ард Улсаас Канад Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар томилсугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

**П. ОЧИРБАТ**

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

1992 оны 1 дүгээр

Дугаар 3

Улаанбаатар

сарын 28-ны өдөр

ХОТ

**ГЭНДЭНГИЙН НИЯМДООГ ЭЛЧИН САЙДЫН  
ҮҮРЭГТ АЖЛААС ЧӨЛӨӨӨЛӨХ ТУХАЙ**

Гэндэнгийн Нямдоог Бүгд Найрамдах Монгол Ард Улсаас Канад Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

**П. ОЧИРБАТ**

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

1992 оны 1 дугаар

Дугаар 5

Улаанбаатар

сарын 28-ны өдөр

хот

**ИШЦОГИЙН ОЧИРБАЛЫГ ЭЛЧИН САЙДЫН  
ҮҮРЭГТ АЖЛААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ**

Ишцогийн Очирбалыг Бүгд Найрамдах Монгол Ард Улсаас Данийн Вант Улс, Нидерландын Вант Улс, Шведийн Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

**П. ОЧИРБАТ**

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

1992 оны 2 дугаар

Дугаар 7

Улаанбаатар

сарын 1-ний өдөр

хот

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙГ УЛС  
ДАЯАР МӨРДӨЖ ЭХЭЛСНИЙГ ЗАРЛАН  
ТУНХАГЛАХ ЕСЛОЛ ҮЙЛДЭХ ТУХАЙ**

1. Монгол Улсын Үндсэн хуулийг 1992 оны хоёрдугаар сарын 12-ны өдрийн 12 цагт буюу арван долдугаар жорны усан бичиг жуагийн хэргийн тэргүүн хар барс сарын тунгийн өсний өдрийн барилдаагаатай өлзийт сайн шар морин өдрийн морин цагаас улс даяар дагаж мөрдөж эхэлснийг нийтэд зарлан тунхаглаж ийнсэв. Улаанбаатар хотноо Д. Сүхбаатарын нэрэмжит талбайд төрийн шинэ бэлгэ тэмдэгийг өргөн мандуулах ёслол үйлдсүгэй.

2. Энэ үеэр нийт аймаг, хот, сум, хороо, дүүрэг, орон нутгийн хотын төвд ёслолын цуглаан хийсүгэй.

3. Ёслол үйлдэх энэ мөчид Монгол Улсын Төрийн шинэ далбааг Төрийн ордон, аймаг, хот, сум, хороо, дүүрэг, орон нутгийн хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дээр хүндэтгэвтэйгээр өргөн мандуулсугай.

4. Монгол улсаас гадаад улс, олон улсын байгууллагад суугаа бүрэн эрхт төлөөлөгчийн газруудад тухайн улсын цагаар мөн өдрийн 12 цагт Монгол Улсын Төрийн шинэ далбааг өргөн мандуулсугай.

5. Монгол улсын Төрийн шинэ далбааг өргөн мандуулах үеэр Төрийн дууламыг улс даяар ягшиглуулсугай.

6. Мөн цагт ёслолын буудлага хийхийг Батлан хамгаалагч сайд дэслэгч генерал Ш. Жадамбаад үүрэг болгосугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

## БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРАЛГ

1992 оны 2 дугаар

Дугаар 15

Улаанбаатар

ардын 10-ны өдөр

107

## МОНГОЛЫН АРД ТҮМНИЙ АХМАД ҮЕИЙН ТАЛААР БАРИМТЛАХ ТӨРИЙН БОДЛОГЫН ТУХАЙ

1. Монголын ард түмний бахархал болсон ахмад үеийнхний талаар төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, орон нутгийн өөрөө удирдах байгууллагууд, улс, хоршоолол, хувийн үйлдвэр, аж

ахуй, зэвсэгт хүчин, ишиглах ухаан, соёл, боловсрол, эрүүл мэндийн бололцол нам, өлөн нийтийн бусад байгууллага, ард иргэдээс үйл ажиллагаандаа нэрлэж болгон хэрэгжүүлэх төрийн бодлогын үндсэн агуулгыг зөвшөөрч хавсралтаар баталсугай.

2. Төрийн энэхүү бодлогыг энг баримжаа болгон ардын хувьсгалын партизан, ахмад дайчид, тэтгэврийн хүмүүст ажиллуулж байсан байгууллагаас нь нэмэгдээд тэтгэвэр, тэтгэмж олгох, анхаарах халамж тавих, эрх ашгийг нь хамгаалах, төдгөөрт эмнэлэг, сувцлаах, үйлчилгээний хөнгөлөлттэй нэгдвэл тогтоох, орон сууцны тусламжаа үзүүлэх, хувийн бололцол хөршөөн үйлдвэрлэл эрхлэхэд нь тусламж дэмжлэг зэргээр ахмадуудын нийгэмийн асуудлуудыг шийдвэрлэх хууль зүйн үндэслэлийг бүрдүүлэх боловсролгүй болгох зорилгоор зохих хууль тогтоомжинд тусган хэрэгжүүлэх бодит арга хэмжээ авч байхыг төрийн хууль тогтоох болон гүйцэтгэх дээд байгууллагуудад зөвлөсүгэй.

Бүгд Найрэмдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРСАТ

БНМАУ-ын Ерөнхийлөгчийн 1992 оны  
2 дугаар сарын 10-ны өдрийн 13 дугаар  
зарлигийн хавсралт

## МОНГОЛЫН АРД ТҮМНИЙ АХМАД ҮСИЙН ТАЛААР БАРИМТЛАХ ТӨРИЙН БОДЛОГО

Монгол улсынхаа төрийн тусгаар тогтнол, аюулгүй байдал, ард түмнийхээ бүтээн байгуулалт, зүх төвшин амьдралыг өнгөөрөн төвхнүүлж оюун билэг, идэвх зүтгэлээ дайчлан үеэс үед өсдүүлэн өсүүлж ирсэн ихэс дээдэс, эцэг өнгөднийхөө амь бие хайргүй хөдөлмөр тэмцлийн мөн чанар, нэр төрлийг сөвтээлгүй байжуулж, үндэснийхээ бахархал, но уламжлал, ардчилсан нийтлэг зарчим, соёл иргэншлийг сэргээн мандуулахад монголын ард түмний ахмад үсийн талаар баримтлах төрийн бодлого чиглэгдэнэ.

1. Ахмад настан бүр төр, засгийнхаа ивээл эвэрллийг эдэлж, түүхэнд нэр төрөө үлдээх, гавъяа дурсгалыг мөнхжүүлэх, тэт-



гүлэр тэтгэмж эрэх, эрх ашгийг нь нийгмийн зүгээс хуульчлан баталгаажуулаж, ёсчлон биелүүлж байна. Ороо бусгаа цагийн нугачаа, одоо ба ирээдүйд огоорон гэж огт үл болох нийт үндэсний нийтлэг ашиг сонирхол бол жаргал зовлонгоо хуваалцан бие биесвэ хүндэтгэж ирсэн монгол түмний хамтач үзэл хүмүүжид мөн.

2. Аав ээж, ах эгчээ асран тэтгэх, ахмад настныг энэрэн хүндэтгэж тэднээс мөнгөл үхээн, соёл иргэншил, шашин суртлаа өвлөн эзэмших, өвөг, эрхийн тэргүүнийг хүндэтгэн, үг сургаалыг нь хичээн хэрэгжүүлэх нь хүүхэд залуучууд, бүстэй бүсгүй бүх иргэний мөрдөн дагах хүнлэг ёс, дэг журам байх болно. Өвөг, хөгшдөө ачлах аваас эргэх цагийн ээлжинд өөрсдөө үр эгээрээ түшүүлэх болно.

3. Улс үндэснийхөө тусгаар тогтнол, эрх чөлөө, ардчилал, ард түмнийхээ сайн сайхан аж байдалыг төлөө тэмцэж явсан үе үеийн эх орончдын зүтгэл бүтээлийг алдаа онооны дэнс, авах гэхийн ухаанаар түүхэн тодорхой нохцол байдалтай нь холбоон тунгааж, өнөө болон ирээдүйн амьдрал үйлсдээ сургамж болгон мөрдөж нигэрөгч хугацааны хол, ойр цагийн уламжлалаас ашиглаж дөвшиндтэй үзэл санаа, үйл хэргийг нь залган үргэлжлүүлж, ахмад үеэ хүндэтгэн дээдэлж, сэтгэл санааны дэмжлэг үзүүлж байна.

Ажилдуулаж байгаад тэтгэвэрт гаргасан байгууллага бүр ахмадуудтайгаа тогтмол холбоотой байж нэмэгдэл тэтгэвэр олгох, мэдлэг чадавч, туршлага авьяастаа тулгуурлан аж ахуй эрхлэх, чадамгай хирээр нийгэмдээ тус хүргэх, аж төрөх арга ухаанаа хойч үедээ өвлүүлэх бололцоогоор хангах, хүмүүсийг стабилтвөгс замгаалах, урт наслуулах, доройтож ядарсан үед нь гэр орноор нь ахуйн болон эмнэлгийн үйлчилгээнд хамруулах, мэтгөлсөлттэйгээр суннаах, асрамжаах зэргээр халамжлах нь гэр засаг, улс төр, олон нийт, цэрэг иргэний бүх шатны нийт байгууллагын журамт үүрэг мөн.

Иргэний нийгэмд нэг ч хүн, тэгэх тусмаа ахмад буурлууд нийгмийн болон олон түмний анхварал халамжаар гачигдах, эзэнгүйдэн завсардах учиргүй.

Ахмад үеийн амьдрал тэмцэлийн түүхэн замнал, баялаг туршлагыг соёл урлаг, хэвлэл мэдээллийн хийгээд ахмадын болон олон нийтийн байгууллагаас эрхлэн нийтийн хүртээл болгож байна.

Хувийн болон хувь нийлүүлсэн аж ахуй эрхлэх, үйлдвэрлэлд гэр бие оролцоход нь улсын байгууллага дэмжлэг тусламжаа үзүүнэ.

4. Асран халамжлах хүнгүй, тахир дутуу, дайнд оролцсон, биеэ арчлах боломж муутай ахмадуудад зориулан төрийн болон нийгмийн хандивын үндсэн дээр энэргийн сан байгуулж идуу буурай ахмадуудын амьдрал ахуйг тэтгэхэд эн түрүүнд анзаарч энэ талаар бусад орны дэвшилттэй арга туршлагыг авч хэрэглэхийг эрхэмлэнэ. Шаардлагатай тохиолдолд сум, дүүргийн захиргаа хуулийн дагуу асрамж, дэмжлэг тогтоож халамжилна.

5. Ахмад буурлууд үр ач нараа амьдралын баялаг туршлагаараа сурган хүмүүжүүлж, ард түмнийхээ уламжлалт зан үйлд сургах, ажил үйлс, гал голомт, өмч хөрөнгөө өвлүүлэх, тэднийг өөрсдөөсөө ч жаргалтай амьдруулахын төлөөнөө хойч үе, орчмы хүмүүстээ эх оронч үзэл, үндэсний ухамсар, иргэний эр зориг, хөдөлмөрч хүмүүжлээрээ үлгэр жишээ үзүүлж, уйгагүй хичээн чармайх үүрэг хүлээнэ.

---

Сэтгүүлийн эрхлэгч Б. Чингид  
Эмхтгэгч Ч. Жагтгасайхан  
Техник редактор С. Завиждмаа  
Хийгэгч С. Итгэл

Үндэсний шинэжүүлсэн 1992 оны 2-р сарын 26-нд  
Өрбөлгөд 1992 оны 2-р сарын 28-нд, Хөвсгөлд  
1992 оны 3-р сарын 24-нд. Цэвэр хэмжээ  
60x84/16, Хөвсгөлийн хуудас 4,25, Хэвлэсэн тоо  
6500 ширхэг.

Засгийн газрын хэвлэх үйлдвэр